



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2023 оны 08 дугаар сарын 28
№32 (1280)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

457.	Иргэний нисэхийн тухай /Шинэчилсэн найруулга/	2449
458.	Иргэний нисэхийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай	2475
459.	Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	2476
460.	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	2479
461.	Улсын нисэхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	2480
462.	Агаарын зайг нисэхэд ашиглах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	2481
463.	Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	2483
464.	Монгол Улсын хилийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	2484
465.	Төмөр замын тээврийн тухай /Шинэчилсэн найруулга/	2485
466.	Хууль хүчингүй болсонд тооцох тухай	2513
467.	Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	2514
468.	Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2518
469.	Зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	2520
470.	Авто замын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	2521
471.	Барилгын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	2522
472.	Төмөр замын тээврийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай	2523



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- | | | | |
|------|---|-----------|------|
| 473. | Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Дугаар 71 | 2526 |
| 474. | Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Дугаар 72 | 2528 |

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- | | | | |
|------|---------------------------|-----------|------|
| 475. | Дүрэм, журам батлах тухай | Дугаар 42 | 2530 |
|------|---------------------------|-----------|------|

	<p style="text-align: center;">ᠰᠠᠭᠠᠨ ᠮᠣᠩᠭᠣᠯ᠎ᠠ ᠲᠤᠮᠤᠳᠡᠭᠡᠯ</p>	
᠒᠔᠗᠐	ᠰᠠᠭᠠᠨ ᠲᠤᠮᠤᠳᠡᠭᠡᠯ /ᠰᠠᠭᠠᠨ ᠲᠤᠮᠤᠳᠡᠭᠡᠯ/	᠕᠗᠒᠗
᠒᠔᠗᠑	ᠰᠠᠭᠠᠨ ᠲᠤᠮᠤᠳᠡᠭᠡᠯ /ᠰᠠᠭᠠᠨ ᠲᠤᠮᠤᠳᠡᠭᠡᠯ/	᠕᠗᠒᠘
᠒᠔᠗᠒	ᠰᠠᠭᠠᠨ ᠲᠤᠮᠤᠳᠡᠭᠡᠯ /ᠰᠠᠭᠠᠨ ᠲᠤᠮᠤᠳᠡᠭᠡᠯ/	᠕᠗᠒᠙
᠒᠔᠗᠓	ᠰᠠᠭᠠᠨ ᠲᠤᠮᠤᠳᠡᠭᠡᠯ /ᠰᠠᠭᠠᠨ ᠲᠤᠮᠤᠳᠡᠭᠡᠯ/	᠕᠗᠓᠐
᠒᠔᠗᠔	ᠰᠠᠭᠠᠨ ᠲᠤᠮᠤᠳᠡᠭᠡᠯ /ᠰᠠᠭᠠᠨ ᠲᠤᠮᠤᠳᠡᠭᠡᠯ/	᠕᠗᠓᠑
᠒᠔᠗᠕	ᠰᠠᠭᠠᠨ ᠲᠤᠮᠤᠳᠡᠭᠡᠯ /ᠰᠠᠭᠠᠨ ᠲᠤᠮᠤᠳᠡᠭᠡᠯ/	᠕᠗᠓᠒
᠒᠔᠗᠖	ᠰᠠᠭᠠᠨ ᠲᠤᠮᠤᠳᠡᠭᠡᠯ /ᠰᠠᠭᠠᠨ ᠲᠤᠮᠤᠳᠡᠭᠡᠯ/	᠕᠗᠓᠓
᠒᠔᠗᠗	ᠰᠠᠭᠠᠨ ᠲᠤᠮᠤᠳᠡᠭᠡᠯ /ᠰᠠᠭᠠᠨ ᠲᠤᠮᠤᠳᠡᠭᠡᠯ/	᠕᠗᠓᠔
᠒᠔᠗᠘	ᠰᠠᠭᠠᠨ ᠲᠤᠮᠤᠳᠡᠭᠡᠯ /ᠰᠠᠭᠠᠨ ᠲᠤᠮᠤᠳᠡᠭᠡᠯ/	᠕᠗᠓᠕
᠒᠔᠗᠙	ᠰᠠᠭᠠᠨ ᠲᠤᠮᠤᠳᠡᠭᠡᠯ /ᠰᠠᠭᠠᠨ ᠲᠤᠮᠤᠳᠡᠭᠡᠯ/	᠕᠗᠓᠖
᠒᠔᠘᠐	ᠰᠠᠭᠠᠨ ᠲᠤᠮᠤᠳᠡᠭᠡᠯ /ᠰᠠᠭᠠᠨ ᠲᠤᠮᠤᠳᠡᠭᠡᠯ/	᠕᠗᠓᠗
᠒᠔᠘᠑	ᠰᠠᠭᠠᠨ ᠲᠤᠮᠤᠳᠡᠭᠡᠯ /ᠰᠠᠭᠠᠨ ᠲᠤᠮᠤᠳᠡᠭᠡᠯ/	᠕᠗᠓᠘
᠒᠔᠘᠒	ᠰᠠᠭᠠᠨ ᠲᠤᠮᠤᠳᠡᠭᠡᠯ /ᠰᠠᠭᠠᠨ ᠲᠤᠮᠤᠳᠡᠭᠡᠯ/	᠕᠗᠓᠙
᠒᠔᠘᠓	ᠰᠠᠭᠠᠨ ᠲᠤᠮᠤᠳᠡᠭᠡᠯ /ᠰᠠᠭᠠᠨ ᠲᠤᠮᠤᠳᠡᠭᠡᠯ/	᠕᠗᠔᠐
᠒᠔᠘᠔	ᠰᠠᠭᠠᠨ ᠲᠤᠮᠤᠳᠡᠭᠡᠯ /ᠰᠠᠭᠠᠨ ᠲᠤᠮᠤᠳᠡᠭᠡᠯ/	᠕᠗᠔᠑

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 07 дугаар
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилго

1.1.Энэ хуулийн зорилго нь Монгол Улсын нутаг дэвсгэр, агаарын зайд иргэний агаарын хөлгөөр нислэг үйлдэх, нисэхийн аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Иргэний нисэхийн хууль тогтоомж

2.1.Иргэний нисэхийн хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль¹, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хуулиар дараах харилцааг зохицуулна:

3.1.1.Монгол Улсын иргэний нисэхийн үйл ажиллагаа;

3.1.2.Монгол Улсын нутаг дэвсгэрт байрлаж байгаа болон агаарын зайд нислэг үйлдэж байгаа иргэний агаарын хөлгийн үйл ажиллагаа;

3.1.3.гадаад улсын хуульд өөрөөр заагаагүй бол тухайн улсын нутаг дэвсгэрт байрлаж байгаа Монгол Улсын бүртгэлтэй болон Монгол Улсын агаарын тээвэрлэгчийн агаарын хөлгийн үйл ажиллагаа;

3.1.4.Монгол Улсын агаарын зайд нислэг үйлдэж байгаа байлдааны үүргийн нислэгээс бусад улсын агаарын хөлгийн нислэгийн хөдөлгөөнийг удирдахтай холбогдсон харилцаа.

¹ Монгол Улсын Үндсэн хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 1992 оны 01 дугаарт нийтлэгдсэн.

4 дүгээр зүйл.Иргэний нисэхийн үйл ажиллагаанд баримтлах зарчим

4.1.Иргэний нисэхийн үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална:

- 4.1.1.аюулгүй;
- 4.1.2.үр ашигтай;
- 4.1.3.хүртээмжтэй.

5 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

5.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

5.1.1.“агаарын навигацийн байгууламж” гэж агаарын навигацийн үйлчилгээнд ашиглаж байгаа барилга байгууламж, тоног төхөөрөмжийг;

5.1.2.“агаарын навигацийн үйлчилгээ” гэж агаарын зайд үйлдэж байгаа нислэгийн бүх үе шатанд үзүүлэх нислэгийн хөдөлгөөний менежмент, холбоо, навигаци, ажиглалт, нисэхийн мэдээлэл, нисэхийн цаг уурын үйлчилгээ болон эрэн хайх, авран туслах үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл дамжуулах цогц үйл ажиллагааг;

5.1.3.“агаарын тээвэрлэгч” гэж Иргэний нисэхийн дүрмийн дагуу олгосон агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч хуулийн этгээдийг;

5.1.4.“агаарын хөлөг” гэж агаарын өгсөх урсгалын нөлөөллөөр бус, өөрөө агаартай харилцан үйлчилсний хүчинд агаарт тогтож, хөдөлгөөн хийж чадах төхөөрөмжийг;

5.1.5.“аюулгүй байдлын зөвлөмж” гэж шинжлэн шалгах ажиллагааны үр дүнд, эсхүл аюулгүй байдлын талаар гаргасан судалгаа болон бусад эх үүсвэрийг үндэслэн агаарын хөлгийг ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах эрх бүхий байгууллагаас гаргасан баримт бичгийг;

5.1.6.“аюулгүйн үзлэг” гэж хөндлөнгийн хууль бус үйлдэлд ашиглаж болзошгүй зэвсэг, тэсрэх бодис, бусад аюултай хэрэгсэл, эд зүйлс, бодисыг илрүүлэхэд чиглэсэн техникийн болон бусад арга хэрэгслээр хийх үзлэгийг;



5.1.7.“аэродром” гэж агаарын хөлгийг байрлуулах, хөөргөх, буулгах, явгалахад зориулан тоногдсон газар, талбай, усан гадаргууг;

5.1.8.“зөрчил” гэж агаарын хөлгийн аюулгүй байдалд нөлөөлж байгаа, эсхүл нөлөөлж болох ослоос бусад эрсдэл бүхий тохиолдлыг;

5.1.9.“Иргэний нисэхийн дүрэм” гэж Олон улсын иргэний нисэхийн тухай конвенц /цаашид “Конвенц” гэх/-ын хавсралтад заасан стандартын суурь түвшнийг хангах зорилгоор энэ хуульд нийцүүлэн гаргасан нисэхийн аюулгүй байдлыг зохицуулах баримт бичгийг;

5.1.10.“иргэний нисэхийн үйл ажиллагаа” гэж иргэний агаарын хөлгөөр үйл ажиллагаа гүйцэтгэхтэй холбоотой цогц ажиллагааг;

5.1.11.“Монгол Улсын агаарын зай” гэж Монгол Улсын нутаг дэвсгэрээс дээших агаар мандлын орон зайг;

5.1.12.“нислэг” гэж агаарын хөлөг зогсоолоос хөдлөхөөс эхлэн хөөрөх, нисэх, газарт бууж, хөдөлгөөнөө бүрэн зогсоох хүртэлх үйл явцыг;

5.1.13.“нислэгийн аюулгүй байдал” гэж нислэгийн үйл ажиллагаа, түүнд шууд дэмжлэг үзүүлэх бусад үйл ажиллагааг хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулахгүйгээр гүйцэтгэхийг;

5.1.14.“нислэгт тэнцэх чадвар” гэж агаарын хөлөг, түүний бүрдэл хэсэг нислэгийн аюулгүй байдлын шаардлагад нийцэж байгаа байдлыг;

5.1.15.“нисэх буудал” гэж аэродром, агаарын тээврийн үйлчилгээний барилга байгууламжийн цогцолборыг;

5.1.16.“нисэхийн аюулгүй байдал” гэж нислэгийн үйл ажиллагаа, түүнд хамаарах нисэхийн бусад үйл ажиллагааны эрсдэлийг хүлээн зөвшөөрөгдөх түвшинд хадгалах тогтолцоог;

5.1.17.“нисэхийн аюулгүйн хамгаалалт” гэж иргэний нисэхийг хөндлөнгийн хууль бус үйлдлээс хамгаалах цогц үйл ажиллагааг;

5.1.18.“нисэхийн гэрчилгээжсэн ажилтан” гэж Иргэний нисэхийн дүрмийн дагуу олгосон үнэмлэх, гэрчилгээ зээмшигчийг;

5.1.19.“осол” гэж Конвенцын 13 дугаар хавсралтад заасныг;

5.1.20.“шинжлэн шалгах” гэж агаарын хөлгийг осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, осол, зөрчилд нөлөөлсөн хүчин зүйл бүрийг тогтоож, дүгнэлт, аюулгүй байдлын зөвлөмж гаргах үйл ажиллагааг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ИРГЭНИЙ НИСЭХИЙН ТАЛААРХ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН БҮРЭН ЭРХ

6 дугаар зүйл.Улсын Их Хурлын бүрэн эрх

6.1.Улсын Их Хурал иргэний нисэхийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6.1.1.иргэний нисэхийн салбарыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлох;

6.1.2.иргэний нисэхийн талаарх олон улсын гэрээнд Монгол Улс нэгдэн орох, гарах асуудлыг шийдвэрлэх;

6.1.3.хуульд заасан бусад.

7 дугаар зүйл.Засгийн газрын бүрэн эрх

7.1.Засгийн газар иргэний нисэхийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.1.1.иргэний нисэхийн салбарыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого, иргэний нисэхийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх;

7.1.2.хууль тогтоомжид заасны дагуу агаарын харилцааны тухай олон улсын гэрээ байгуулах;

7.1.3.олон улсын гэрээ, хууль тогтоомжид нийцүүлэн иргэний нисэхийн аюулгүй байдлын, нисэхийн аюулгүйн хамгаалалтын болон агаарын тээврийг хялбаршуулах журмыг батлах;

7.1.4.олон улсын нисэх буудал байгуулах, татан буулгах асуудлыг шийдвэрлэх;

7.1.5.иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргыг томилох, чөлөөлөх;

7.1.6.хуульд заасан бусад.



8 дугаар зүйл. Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

8.1. Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

8.1.1. иргэний нисэхийн салбарыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого, хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг хангуулах;

8.1.2. иргэний нисэхийн салбарт төрөөс баримтлах бодлого боловсруулах;

8.1.3. иргэний нисэхийн аюулгүй байдлыг хангуулах;

8.1.4. Иргэний нисэхийн дүрмийг батлах;

8.1.5. иргэний нисэхийн эдийн засгийн зохицуулалтыг хэрэгжүүлэх, хяналт тавих;

8.1.6. олон улсын хуваарьт нислэг үйлдэх агаарын тээвэрлэгчийг томилох;

8.1.7. Монгол Улсын агаарын хилээр агаарын хөлөг нэвтрэн орох, гарах цэгийг батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр тогтоох;

8.1.8. агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааны дүрмийг батлах;

8.1.9. иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах байгууллагын бүтцийг батлах;

8.1.10. агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах байгууллагын дарга бөгөөд Ерөнхий шинжлэн шалгагчийг томилох, чөлөөлөх;

8.1.11. агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааг гадаад улсын эрх бүхий байгууллагатай хамтран гүйцэтгэх, эсхүл тухайн байгууллагад хэсэгчлэн, эсхүл бүрэн шилжүүлэх асуудлыг шийдвэрлэх;

8.1.12. агаарын навигацийн болон Иргэний нисэхийн дүрмийн дагуу гэрчилгээ олгох үйлчилгээний хураамжийн хэмжээг тогтоох;

8.1.13. иргэний нисэхийн хяналтын улсын ерөнхий байцаагч, хяналтын байцаагчийн эрх олгох;

8.1.14.хуульд заасан бусад.

9 дүгээр зүйл.Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, түүний чиг үүрэг

9.1.Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь иргэний нисэхийн аюулгүй байдал, аюулгүйн хамгаалалтын хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэх үүрэг бүхий Засгийн газрын тохируулагч агентлаг байна.

9.2.Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

9.2.1.Конвенцын хавсралтад нийцүүлэн Иргэний нисэхийн дүрэм боловсруулж, эрх бүхий байгууллагаар батлуулах, бүртгүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих;

9.2.2.Конвенцын хэлэлцэн тохиролцогч улсын иргэний нисэхийн байгууллагатай хамтран ажиллах, мэдээлэл харилцан солилцох;

9.2.3.Иргэний нисэхийн дүрэм болон Конвенцын хавсралтад заасан стандартын зөрүүтэй байдлыг Олон улсын иргэний нисэхийн байгууллагад мэдээлэх;

9.2.4.иргэний нисэхийн аюулгүй байдал, аюулгүйн хамгаалалттай холбоотой мэдээллийн санг хөтлөх, холбогдох байгууллагатай мэдээлэл солилцох;

9.2.5.иргэний нисэхийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, агаарын хөлөг, түүний бүрдэл хэсгийн гэрчилгээ, нисэхийн гэрчилгээжсэн ажилтны үнэмлэх, гэрчилгээ, зэрэглэл олгох.

9.3.Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь иргэний нисэхийн аюулгүй байдал болон аюулгүйн хамгаалалтын хяналт, зохицуулалтыг тасралтгүй, үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөц, санхүүгийн чадавхтай байна.

10 дугаар зүйл.Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга, түүний бүрэн эрх

10.1.Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга бөгөөд иргэний нисэхийн хяналтын улсын ерөнхий



байцаагч /цаашид “Дарга” гэх/ иргэний нисэхийн мэргэжлийн дээд боловсролтой, иргэний нисэхийн хяналтын байцаагчид тавигдах шаардлагыг хангасан байна.

10.2.Дарга Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуульд² заасан нийтлэг бүрэн эрхээс гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

10.2.1.иргэний нисэхийн аюулгүй байдлыг хариуцах;

10.2.2.иргэний нисэхийн хяналтын байцаагчийг томилох, чөлөөлөх;

10.2.3.иргэний нисэхийн дүрмийн тайлбар, хүсэлт гаргах маягт, бүртгэлийн дэвтэр, техник, технологийн баримт бичгийг батлах, тэдгээрт өөрчлөлт оруулах;

10.2.4.аюулгүй байдлын зөвлөмжийг үндэслэн агаарын хөлгийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах;

10.2.5.нислэгийн аюулгүй байдалд нөлөөлж болзошгүй Иргэний нисэхийн дүрмээр зохицуулагдаагүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд тодорхой хугацаатай шийдвэр гаргаж, холбогдох этгээдэд мэдээлэх;

10.2.6.нислэгт тэнцэх чадвараа алдсан агаарын хөлгийн нислэгийг зогсоох, зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох;

10.2.7.хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулж болзошгүй тохиолдолд нислэгийг зогсоох арга хэмжээг авах;

10.2.8.хууль болон албадан хэрэгжүүлэх дүрмийн дагуу хүн, хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэх, зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох арга хэмжээг авах;

10.2.9.аюулгүйн үзлэг, хамгаалалт шаардлагатай нисэх буудал болон агаарын навигацийн байгууламжийн жагсаалтыг батлах;

10.2.10.Иргэний нисэхийн дүрэмд заасны дагуу тус дүрмийн шаардлагаас чөлөөлөх;

10.2.11.хуульд заасан бусад.

² Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2004 оны 16 дугаарт нийтлэгдсэн.

11 дүгээр зүйл.Эрх шилжүүлэх

11.1.Дарга иргэний нисэхийн аюулгүй байдал болон аюулгүйн хамгаалалтын хяналт шалгалт хийх эрхээ иргэний нисэхийн хяналтын байцаагч болон нисэхийн гэрчилгээжсэн ажилтанд гэрээгээр бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн шилжүүлж болно.

11.2.Дарга энэ хуулийн 11.1-д заасан эрхээ шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

11.3.Энэ хуулийн 11.1-д заасан эрхийг шилжүүлэх журмыг Монгол Улсын олон улсын гэрээ, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЗОХИЦУУЛАЛТ

12 дугаар зүйл.Иргэний нисэхийн дүрмийн зохицуулалт

12.1.Дараах үйл ажиллагааг Конвенцын хавсралтад нийцүүлэн Иргэний нисэхийн дүрмээр зохицуулна:

12.1.1.Иргэний нисэхийн дүрмийн нэр томъёоны тайлбарыг батлах;

12.1.2.Монгол Улсад иргэний агаарын хөлгийг бүртгэх, нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ олгох, агаарын хөлөг, бүтээгдэхүүн, эд ангийг гэрчилгээжүүлэх, нислэгт тэнцэх чадварын удирдамж гаргах, техникийн үйлчилгээний ерөнхий шаардлагыг тогтоох;

12.1.3.хувь хүнд мэргэжлийн үнэмлэх, зэрэглэл, эрүүл мэндийн гэрчилгээ олгох;

12.1.4.ерөнхий зориулалтын нисэхийн үйл ажиллагаа эрхлэх;

12.1.5.Иргэний нисэхийн дүрмийг албадан хэрэгжүүлэх, дүрмийн шаардлагаас чөлөөлөх;

12.1.6.осол, зөрчлийг мэдээлэх;

12.1.7.агаарын зайг тогтоох, ангилах болон агаарын зайн зохицуулалт хийх;

12.1.8.нислэгийн үйл ажиллагааны ерөнхий шаардлагыг тогтоох;



12.1.9. аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх;

12.1.10. хүнгүй агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийг гэрчилгээжүүлэх;

12.1.11. агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалт;

12.1.12. агаарын хөлгөөр аюултай барааг тээвэрлэх болон зохицуулалттай агаарын ачааны байгууллагыг гэрчилгээжүүлэх;

12.1.13. том, дунд, жижиг оврын агаарын хөлгийн нислэгийн үйл ажиллагаа болон дотоод, гадаадын агаарын тээвэрлэгчийг гэрчилгээжүүлэх;

12.1.14. нисдэг тэргээр дүүжин ачаа тээвэрлэх, агаараас ажил гүйцэтгэх болон чөлөөт нисэхийн үйл ажиллагаа эрхлэгчийг гэрчилгээжүүлэх;

12.1.15. аэродром байгуулах, аэродромыг гэрчилгээжүүлэх;

12.1.16. нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний байгууллагыг гэрчилгээжүүлэх;

12.1.17. нисэхийн сургалтын байгууллагыг гэрчилгээжүүлэх;

12.1.18. агаарын хөлөг зохион бүтээх, үйлдвэрлэх, техникийн үйлчилгээ хийх байгууллагыг гэрчилгээжүүлэх;

12.1.19. шүхэр, хэт хөнгөн агаарын хөлгөөр сонирхогчийн үйл ажиллагаа эрхлэгчийг гэрчилгээжүүлэх;

12.1.20. агаарын навигацийн техникийн үйлчилгээ, нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ, хэрэглэлийн нислэгийн журам боловсруулах, нисэхийн цаг уурын болон нисэхийн мэдээллийн үйлчилгээний байгууллагыг гэрчилгээжүүлэх;

12.1.21. олон улсын гэрээнд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн дагуу батлах бусад дүрэм.

13 дугаар зүйл. Иргэний нисэхийн эдийн засгийн зохицуулалт

13.1. Иргэний нисэхийн дараах үйл ажиллагааг эдийн засгийн зохицуулалтын дүрмээр зохицуулна:

13.1.1. олон улсын хуваарьт нислэг үйлдэх агаарын тээвэрлэгчийг томилох;

13.1.2.иргэний нисэхийн төлбөртэй үйлчилгээний төрөл, төлбөрийн хэмжээг тогтоох;

13.1.3.зорчигч, тээш, ачаа тээвэрлэлтийн ерөнхий нөхцөл;

13.1.4.агаарын тээвэрлэгчийн даатгал;

13.1.5.иргэний нисэхийн статистикийн мэдээлэл цуглуулах, түгээх;

13.1.6.иргэний нисэхийн салбарын хөрөнгө оруулалтын зардал, үр ашгийн тооцоо хийх;

13.1.7.агаарын навигаци, нисэх буудал болон агаарын тээврийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагын хөрөнгө оруулалт, аюулгүй байдлыг хангах санхүүгийн чадавхад үнэлгээ хийх;

13.1.8.хуульд заасан бусад.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ АГААРЫН ХӨЛӨГ, ТҮҮНД ХАМААРАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

14 дүгээр зүйл. Агаарын хөлөг, түүний бүрдэл хэсгийн бүртгэл

14.1.Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага Монгол Улсад бүртгэх агаарын хөлөг, түүний бүрдэл хэсгийн бүртгэлийг хөтөлнө.

14.2.Хүн, хуулийн этгээд өөрийн өмчлөл, эзэмшилд байгаа, бусад улсад бүртгэлгүй агаарын хөлгийг Иргэний нисэхийн дүрмийн дагуу Монгол Улсын агаарын хөлгийн бүртгэлд бүртгүүлнэ.

14.3.Бүртгэлгүй агаарын хөлгөөр Монгол Улсын агаарын зайд нислэг үйлдэхийг хориглоно.

14.4.Энэ хууль болон Иргэний нисэхийн дүрмийг зөрчсөн тохиолдолд агаарын хөлгийн бүртгэлийн гэрчилгээг түдгэлзүүлэх, эсхүл хүчингүй болгоно.

14.5.Агаарын хөлгийн бүртгэлийн гэрчилгээ тухайн агаарын хөлгийн үндэсний харьяаллыг гэрчлэх бөгөөд агаарын хөлгийн өмчлөлийг нотлохгүй.

15 дугаар зүйл. Агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадвар

15.1. Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас олгосон, эсхүл хүлээн зөвшөөрсөн маягийн гэрчилгээтэй агаарын хөлгийг нислэгийн үйл ажиллагаанд ашиглана.

15.2. Маягийн гэрчилгээний шаардлага болон үзлэг, шалгалтаар нислэгийн аюулгүй байдлыг хангасан агаарын хөлөгт нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ олгоно.

15.3. Нислэгт тэнцэх чадварын гэрчилгээнд түүний хүчинтэй хугацаа, агаарын хөлгийн зориулалт, нислэгийн аюулгүй байдлыг хангахад шаардлагатай ангилал, хязгаарлалт болон бусад мэдээллийг тусгана.

15.4. Энэ хуулийн 15.2-т хэт хөнгөн агаарын хөлөг, агаарын бөмбөлөг болон агаарын хөлгийн загварын нислэг хамаарахгүй.

15.5. Энэ хуулийн 15.1-д заасан “маягийн гэрчилгээ” гэж тухайн агаарын хөлгийн хийц нислэгт тэнцэх чадварын холбогдох шаардлагад нийцэж байгааг хэлэлцэн тохиролцогч улсын эрх бүхий байгууллагаас тодорхойлж олгосон баримт бичгийг ойлгоно.

16 дугаар зүйл. Нислэгийн үйл ажиллагааны төрөл

16.1. Нислэгийн үйл ажиллагаа нь арилжааны агаарын тээвэр, агаараас гүйцэтгэх ажил, ерөнхий зориулалтын нислэг гэсэн төрөлтэй байна.

16.2. Арилжааны агаарын тээврийн төрөлд зорчигч, ачаа, шууданг төлбөртэй тээвэрлэх, эсхүл эдийн засгийн үр ашиг хүртэх зорилгоор гүйцэтгэх нислэг хамаарна.

16.3. Агаараас гүйцэтгэх ажилд агаарын хөлгөөр хөдөө аж ахуйн ажил гүйцэтгэх, зураг авах, судалгаа, ажиглалт, эргүүл хийх, эрэн хайх, авран туслах, зар сурталчилгаа хийх болон нислэгээр гүйцэтгэх бусад ажил, үйлчилгээ хамаарна.

16.4. Ерөнхий зориулалтын нислэгт арилжааны агаарын тээвэр болон агаараас гүйцэтгэх ажлаас бусад төрлийн нислэг хамаарна.

17 дугаар зүйл. Ерөнхий зориулалтын нисэхийн үйл ажиллагаа

17.1. Ерөнхий зориулалтын нислэгт хувийн болон чөлөөт, хөнгөн, хэт хөнгөн, хүнгүй агаарын хөлгөөр гүйцэтгэх, хэт хөнгөн агаарын хөлгөөр гүйцэтгэх сонирхогчийн нислэг болон тэдгээрт хамаарах бусад нислэг багтана.



17.2.Ерөнхий зориулалтын нислэгийн аюулгүй байдлыг агаарын хөлгийн өмчлөгч, эзэмшигч хариуцна.

17.3.Ерөнхий зориулалтын нисэхийн үйл ажиллагааг Иргэний нисэхийн дүрмээр зохицуулна.

17.4.Ерөнхий зориулалтын нисэхийн үйл ажиллагаанд Иргэний нисэхийн дүрэмд зааснаас бусад хязгаарлалт тогтоохыг хориглоно.

18 дугаар зүйл.Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ

18.1.Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага энэ хууль болон иргэний нисэхийн холбогдох дүрэмд заасан шаардлага хангасан Монгол Улсын хуулийн этгээдэд агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ олгоно.

18.2.Гадаад улсын эрх бүхий байгууллагаас томилогдсон агаарын тээвэрлэгч энэ хууль болон Иргэний нисэхийн дүрмийн шаардлагыг хангасан бол түүнд гадаадын агаарын тээвэрлэгчийн Монгол Улсын гэрчилгээ олгож болно.

18.3.Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээг бусдад шилжүүлэхийг хориглоно.

19 дүгээр зүйл.Агаарын тээвэрлэгчийн үүрэг

19.1.Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа агаарын тээвэрлэгч дараах үүрэгтэй:

19.1.1.нислэгийн үйл ажиллагааг агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ болон түүнд заасан эрх, хязгаарлалтын хүрээнд гүйцэтгэх;

19.1.2.нислэгийн үйл ажиллагааны болон нислэгт тэнцэх чадварын шаардлагыг хангасан заавар, журам боловсруулж, мөрдөх;

19.1.3.нийтийн ашиг сонирхолд нийцсэн үйлчилгээ үзүүлэх.

20 дугаар зүйл.Иргэний агаарын хөлгийн баг

20.1.Иргэний агаарын хөлгийн баг нь нисгэгч болон багийн бусад гишүүнээс бүрдэнэ.

20.2.Нислэгийн үед нислэгтэй холбогдох үйл ажиллагаа явуулах нисгэгчээс бусад ажилтан агаарын хөлгийн багийн бусад гишүүнд хамаарна.

20.3.Монгол Улсын иргэний агаарын хөлгийн багийн бүрэлдэхүүнд гадаад улсын иргэн байж болно.

21 дүгээр зүйл. Агаарын хөлгийн дарга, түүний бүрэн эрх

21.1. Агаарын тээвэрлэгч нислэгийн аюулгүй байдлыг хангах зорилгоор тухайн төрлийн нислэгийн үйл ажиллагааг гүйцэтгэх шаардлага хангасан нисгэгчийг агаарын хөлгийн даргаар томилно.

21.2. Агаарын хөлгийн дарга нислэгийн аюулгүй байдлыг хангах, хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг хамгаалах зорилгоор агаарын хөлгийн багийн гишүүд болон зорчигчид шаардлага тавьж, биелэлтийг хангуулах бөгөөд нислэгтэй холбоотой эцсийн шийдвэрийг гаргана.

21.3. Агаарын хөлгийн дарга дараах онцгой нөхцөлд Иргэний нисэхийн дүрэмд зааснаас өөр шийдвэр гаргах эрхтэй:

21.3.1. хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд аюул тулгарсан;

21.3.2. нислэгийг хэвийн үргэлжлүүлэх боломжгүй нөхцөлийг зохицуулах шаардлагатай болсон.

21.4. Агаарын хөлгийн дарга нислэгийн аюулгүй байдалд илт аюул тулгарсан тохиолдолд агаарын хөлөг болон түүний бүхээгт байгаа хүмүүсийн амь насыг аврах зорилгоор нислэгийн төлөвлөгөө болон нислэгийн хөдөлгөөний удирдагчийн өгснөөс өөр шийдвэр гаргаж болно.

21.5. Гадаад улсын агаарын зайд нислэг үйлдэж байгаа агаарын хөлгийн дарга албадан саатуулагдах нөхцөл байдалд орсон тохиолдолд тухайн улсын эрх бүхий байгууллагаас тавьсан шаардлагыг дагаж мөрдөх үүрэгтэй.

22 дугаар зүйл. Нислэгийн үеийн дэг журам

22.1. Зорчигч нь агаарын хөлгийн багийн гишүүдээс өгсөн зааварчилгааг нислэгийн туршид дагаж мөрдөх үүрэгтэй.

22.2. Агаарын хөлгийн багийн гишүүн нислэгийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй үйлдэл гаргасан, гаргахыг завдсан зорчигчид шаардлага тавьж, аюулгүй байдлыг хангах арга хэмжээг авна.

22.3.Нислэгийн үед дэг журам зөрчсөн зорчигчид авах арга хэмжээний журмыг иргэний нисэхийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

22.4.Агаарын тээвэрлэгч нислэгийн аюулгүй байдалд эрсдэл учруулж болзошгүй, дэг журам зөрчсөн, зөрчиж байсан зорчигчийг тээвэрлэхээс татгалзаж болно.

23 дугаар зүйл.Нислэгийн үйл ажиллагаанд хориглох зүйл

23.1.Нислэгийн үйл ажиллагаанд дараах зүйлийг хориглоно:

23.1.1.нислэгт тэнцэх чадварын шаардлага хангаагүй агаарын хөлөг, түүний бүрдэл хэсгийг ашиглах;

23.1.2.нислэгт тэнцэх чадварын гэрчилгээгүй, эсхүл гэрчилгээний эрх, хязгаарлалтыг зөрчиж үйл ажиллагаа эрхлэх;

23.1.3.агаарын тээвэрлэгчийн гэрчилгээгүй, эсхүл энэ хууль болон Иргэний нисэхийн дүрмийг зөрчиж нислэгийн үйл ажиллагаа эрхлэх;

23.1.4.агаарын хөлөгт гарал үүсэл тодорхойгүй, үйлдвэрлэгчийн техникийн тодорхойлолтод нийцээгүй эд анги ашиглах;

23.1.5.гэрчилгээнд заасан эрх, хязгаарлалтыг зөрчиж агаарын хөлөг, түүний бүрдэл хэсэгт техникийн үйлчилгээ хийх;

23.1.6.агаарын хөлөгтэй холбоотой ажил, үйлчилгээнд нисэхийн гэрчилгээжсэн ажилтны үнэмлэх, гэрчилгээгүй этгээдийг ажиллуулах, гэрчилгээнд заасан эрхээс хэтэрсэн ажил үүрэг гүйцэтгүүлэх;

23.1.7.агаарын хөлгийн багийн гишүүдээс бусад этгээд нисгэгчийн бүхээгт нэвтрэх;

23.1.8.бүрэн бус бүрэлдэхүүнтэй агаарын хөлгийн баг нислэг үйлдэх.

24 дүгээр зүйл.Зөрчил гаргасан агаарын хөлөг

24.1.Монгол Улсын агаарын зайд нислэг үйлдэх болон улсын хилийн орох, гарах цэгээр нэвтрэх журмыг зөрчсөн, эрх бүхий байгууллагын зохих зөвшөөрөлгүйгээр улсын хил нэвтэрсэн агаарын хөлгийг зөрчил гаргасан гэж үзнэ.

24.2. Агаарын навигацийн үйлчилгээний байгууллага энэ хуулийн 24.1-д заасан агаарын хөлгийн талаар Монгол Улсын агаарын зайн аюулгүй байдлыг хангах эрх бүхий байгууллагад мэдэгдэж, агаарын хөлгийн багт зөрчлөө нэн даруй зогсоох, заасан газарт хөлгийг буулгах шаардлага тавина.

25 дугаар зүйл. Аюул тулгарсан агаарын хөлөг

25.1. Агаарын навигацийн үйлчилгээний байгууллага Монгол Улсын нутаг дэвсгэр, агаарын зайд аюул тулгарсан агаарын хөлгийн талаар холбогдох байгууллагад зохих журмын дагуу нэн даруй мэдэгдэнэ.

25.2. Улсын онцгой комисс аюул тулгарсан агаарын хөлгийг эрэн хайх, авран туслах үйл ажиллагааг тухайн агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч, эсхүл бүртгэгч улсын эрх бүхий байгууллагатай хамтран гүйцэтгэнэ.

25.3. Хүн, хуулийн этгээд нь аюул тулгарсан агаарын хөлгийн талаар холбогдох байгууллагад нэн даруй мэдээлэх, хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг хамгаалах, эмнэлгийн болон бусад зайлшгүй шаардлагатай тусламж үзүүлэх үүрэгтэй.

Тайлбар: Энэ хуулийн 25.1-д заасан “аюул тулгарсан агаарын хөлөг” гэж Улсын нисэхийн тухай хуулийн³ 4.1.1-д заасныг ойлгоно.

26 дугаар зүйл. Агаарын тээврийн даатгал

26.1. Агаарын тээвэрлэгч нь зорчигчийн амь нас, эрүүл мэнд, ачаа, тээш, шуудан, эд хөрөнгөд учирсан хохирлыг барагдуулах хариуцлагын даатгалд даатгуулсан байна.

26.2. Агаарын тээвэрлэгч албан үүргээ гүйцэтгэж байгаа агаарын хөлгийн багийн гишүүдийн амь нас, эрүүл мэндийг заавал даатгуулна.

26.3. Монгол Улсын агаарын зайд нислэг үйлдэх агаарын хөлөг гуравдагч этгээдэд учрах хохирлыг хариуцах баталгаа бүхий даатгалд даатгуулсан байна.

26.4. Энэ хуулийн 26.1, 26.2, 26.3-т заасан даатгалын эрсдэл, нөхцөл, үнэлгээ, хураамжийн хэмжээг тогтоох, даатгалын үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих журмыг иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Санхүүгийн зохицуулах хороотой хамтран батална.

³ Улсын нисэхийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2003 оны 23 дугаарт нийтлэгдсэн.

ТАВДУГААР БҮЛЭГ АГААРЫН НАВИГАЦИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

27 дугаар зүйл. Агаарын навигацийн үйлчилгээний байгууллага

27.1. Монгол Улсын агаарын зайд агаарын навигацийн үйлчилгээг Иргэний нисэхийн дүрмээр гэрчилгээжсэн төрийн өмчит хуулийн этгээд /цаашид “агаарын навигацийн үйлчилгээний байгууллага” гэх/ үзүүлнэ.

27.2. Агаарын навигацийн үйлчилгээний байгууллага нь нислэгийн хөдөлгөөнийг аюулгүй, үр ашигтай удирдан зохион байгуулахад чиглэсэн нислэгийн хөдөлгөөний удирдлага, зохицуулалтыг хэрэгжүүлнэ.

27.3. Агаарын навигацийн үйлчилгээний байгууллага энэ хуулийн 27.2-т заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх чадамж бүхий хүний нөөцтэй байна.

28 дугаар зүйл. Нислэгийн хөдөлгөөний зохицуулалт

28.1. Агаарын хөлөг нь Монгол Улсын агаарын хилийн орох, гарах цэгээр нэвтэрч, нислэг үйлдэнэ.

28.2. Агаарын зайн ангилал, бүтэц, зохион байгуулалт, агаарын хөлгийн хоорондын аюулгүйн зайчлал нь Конвенцын хавсралтын стандартын шаардлагад нийцсэн байна.

28.3. Конвенцын хавсралтын стандартын шаардлагад нийцсэн агаарын навигацийн байгууламж, тоног төхөөрөмжийг ашиглан хяналттай агаарын зайд нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ үзүүлнэ.

29 дүгээр зүйл. Агаарын навигацийн үйл ажиллагааны санхүүжилт

29.1. Агаарын навигацийн үйл ажиллагааг агаарын навигацийн үйлчилгээний хураамжийн орлогоор санхүүжүүлнэ.

29.2. Агаарын навигацийн үйлчилгээний хураамжийн орлого нь агаарын навигацийн үйлчилгээг аюулгүй, тасралтгүй үзүүлэх, Конвенцын хавсралтын стандартын суурь түвшнийг хангахад хүрэлцэхгүй тохиолдолд үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардагдах хэмжээгээр улсын төсвөөс санхүүжүүлнэ.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ АЭРОДРОМ, НИСЭХ БУУДАЛ

30 дугаар зүйл.Аэродром

30.1.Монгол Улсын иргэн, хуулийн этгээд Иргэний нисэхийн дүрмийн дагуу аэродром байгуулж болно.

30.2.Агаарын тээврийн үйл ажиллагаанд тогтмол ашиглах аэродромд Иргэний нисэхийн дүрмийн дагуу гэрчилгээ олгоно.

30.3.Нийтэд үйлчлэх аэродромын үйл ажиллагаа эрхлэгч нислэгийн аюулгүй байдлыг зайлшгүй хангах шаардлагатайгаас бусад тохиолдолд агаарын хөлөгт үйлчилгээ үзүүлэхээс татгалзахыг хориглоно.

30.4.Аэродромын үйл ажиллагаа эрхлэгч нь аэродромыг Конвенцын хавсралтын стандартын суурь түвшинд нийцсэн, үйл ажиллагаанд нь тохирсон төхөөрөмжөөр тоноглох үүрэгтэй.

31 дүгээр зүйл.Нисэх буудал

31.1.Нисэх буудал нь олон улсын болон орон нутгийн нислэгт аэродром, нисэхийн хангамж, газрын үйлчилгээ болон бусад нисэхийн ба нисэхийн бус үйлчилгээ үзүүлж болно.

31.2.Аэродромын гэрчилгээ эзэмшигч нь нисэх буудлыг хөгжүүлэх төлөвлөгөөг тухайн хот, аймаг, сумын нутгийн захиргааны байгууллагатай зөвшилцөн төлөвлөнө.

32 дугаар зүйл.Аэродромын аюулгүйн бүс

32.1.Аэродромын аюулгүйн бүсийг аэродромын техник, технологийн баримт бичигт заасны дагуу тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга тогтооно.

32.2.Аэродромын аюулгүйн бүсэд эрхлэх нислэгийн аюулгүй байдалд нөлөөлж болзошгүй үйлдвэрлэл, үйлчилгээ болон барилга байгууламжийн хязгаарлалтыг аэродромын техник, технологийн баримт бичигт зааснаар зохицуулна.

33 дугаар зүйл.Дохио, тэмдэг

33.1.Аэродромын үйл ажиллагаа эрхлэгч нь аэродром болон түүний орчимд агаарын хөлөг хөөрөх, буух, явгалах үед агаарын хөлгийн

чиг баримжаа тогтооход зориулсан тэмдэг, тэмдэглэгээ, тэмдэгт, гэрэл дохионы системийг аэродромын техник, технологийн баримт бичигт заасны дагуу байрлуулж, ашиглана.

33.2.Аэродромын аюулгүйн бүс дэх барилга байгууламжийг өмчлөгч, эзэмшигч нь нислэгийн аюулгүй байдлыг хангахад шаардлагатай саадын дохио, тэмдэг, тэмдэглэгээ, тэмдэгтийг аэродромын техник, технологийн баримт бичигт заасны дагуу байрлуулна.

33.3.Аэродромын аюулгүйн бүсэд агаарын хөлгийн чиг баримжаа тогтооход зориулсан дохио, тэмдэг, тэмдэглэгээ, тэмдэгттэй ижил төстэй зүйл байрлуулахыг хориглоно.

ДОЛДУГААР БҮЛЭГ НИСЭХИЙН АЮУЛГҮЙН ХАМГААЛАЛТ

34 дүгээр зүйл.Нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээ

34.1.Нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээ нь аюулгүйн үзлэг, шалгалт болон нисэх буудал, агаарын навигацийн байгууламжийн харуул хамгаалалтын үйлчилгээнээс бүрдэнэ.

34.2.Нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээг Иргэний нисэхийн дүрмийн дагуу гэрчилгээжсэн хуулийн этгээд /цаашид “нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний байгууллага” гэх/ гүйцэтгэнэ.

34.3.Олон улсын нисэх буудал дахь нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээг Иргэний нисэхийн дүрмийн дагуу гэрчилгээжсэн төрийн өмчит хуулийн этгээд гүйцэтгэнэ.

34.4.Нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний байгууллага аюулгүйн хамгаалалттай холбоотой хууль тогтоомж, Иргэний нисэхийн дүрмийг зөрчсөн этгээдийг эрх бүхий байгууллагад шилжүүлэх зорилгоор түр саатуулах эрхтэй.

34.5.Нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний байгууллага нь үзлэг, шалгалтаар илэрсэн зөвшөөрөгдөөгүй эд зүйлсийг хураан авна.

35 дугаар зүйл.Аюулгүйн үзлэг, шалгалт

35.1.Нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний байгууллага дараах үзлэг, шалгалтыг хийнэ:

35.1.1.аюулгүйн хамгаалалт шаардлагатай нисэх буудал, аэродромын аюулгүйн бүсэд агаарын хөлгийн багийн гишүүн, зорчигч,



нэвтрэн орох бусад этгээд, тээш, ачаа, шуудан, нислэгийн хоол хүнс болон хангамжийн эд зүйлд;

35.1.2. аюулгүйн хамгаалалттай бүсэд болон түүнд нэвтрэхээс өмнө хүн, түүний авч яваа эд зүйл, тээврийн хэрэгсэлд.

35.2. Аюулгүйн үзлэг, шалгалт хийлгэхээс татгалзсан этгээдийг нисэхийн аюулгүйн хамгаалалттай бүсэд нэвтрүүлэхийг хориглоно.

НАЙМДУГААР БҮЛЭГ ИРГЭНИЙ НИСЭХИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХЯНАЛТ

36 дугаар зүйл. Иргэний нисэхийн хяналт

36.1. Иргэний нисэхийн хяналт нь нислэгийн аюулгүй байдлын болон иргэний нисэхийн үйлчилгээнд тавих хяналтаас бүрдэнэ.

36.2. Нислэгийн аюулгүй байдлын хяналт дараах чиглэлтэй байна:

36.2.1. нисэхийн гэрчилгээжсэн ажилтны үнэмлэх, гэрчилгээ;

36.2.2. нислэгийн үйл ажиллагааны стандарт;

36.2.3. агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадвар.

36.3. Иргэний нисэхийн үйлчилгээнд тавих хяналт дараах чиглэлтэй байна:

36.3.1. агаарын навигацийн үйлчилгээ;

36.3.2. нисэх буудал, аэродромын үйлчилгээ;

36.3.3. аюулгүйн хамгаалалтын үйлчилгээ.

37 дугаар зүйл. Иргэний нисэхийн хяналтын байцаагч

37.1. Энэ хуулийн 36 дугаар зүйлд заасан хяналтыг иргэний нисэхийн хяналтын байцаагч /цаашид “хяналтын байцаагч” гэх/ хэрэгжүүлнэ.

37.2. Хяналтын байцаагч нь тухайн хяналт тавих мэргэжлийн чиглэлээр таваас доошгүй жил ажилласан, дээд боловсролтой, иргэний нисэхийн олон улсын эрх зүйн зохицуулалтын зохих мэдлэг, ур чадвартай байна.

37.3. Хяналтын байцаагч өөрийн гаргасан шаардлага, нотолгоо, шийдвэр, дүгнэлтийн үнэн зөвийг бүрэн хариуцна.

38 дугаар зүйл.Иргэний нисэхийн хяналтын байцаагчийн бүрэн эрх

38.1.Хяналтын байцаагч нь Төрийн хяналт шалгалтын тухай хууль⁴, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд⁵ заасан нийтлэг бүрэн эрхээс гадна дараах бүрэн эрхтэй:

38.1.1.хяналт шалгалт хийх зорилгоор иргэний нисэхийн үйл ажиллагаатай холбогдолтой объект, барилга байгууламжид саадгүй нэвтрэх;

38.1.2.иргэний нисэхийн үйл ажиллагаатай холбоотой баримт бичгийн хувийг шаардан гаргуулах;

38.1.3.шаардлагатай тохиолдолд агаарын хөлгийг саатуулах;

38.1.4.шаардлагатай тохиолдолд холбогдох этгээдийн иргэний нисэхийн баримт бичгийг түр хураах;

38.1.5.хуульд заасан бусад бүрэн эрх.

39 дүгээр зүйл.Хяналтын байцаагчийн ажиллах нөхцөл, баталгаа

39.1.Хяналтын байцаагчийн цалингийн хэмжээг иргэний нисэхийн салбарын адилтгах бусад албан тушаалын цалингаас багагүйгээр тогтооно.

39.2.Хяналтын байцаагч түүний эрхийг тодорхой заасан үнэмлэхтэй байна.

39.3.Хяналтын байцаагч дүрэмт хувцас болон хяналт шалгалт хийхэд шаардлагатай тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслээр хангагдсан байна.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ АГААРЫН ХӨЛГИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ ШИНЖЛЭН ШАЛГАХ

40 дүгээр зүйл.Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагаа

⁴ Төрийн хяналт шалгалтын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2003 оны 02 дугаарт нийтлэгдсэн.

⁵ Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2017 оны 24 дугаарт нийтлэгдсэн.

40.1. Агаарын хөлөг өмчлөгч, эзэмшигч, иргэний нисэхийн үйл ажиллагаа эрхлэгч, агаарын хөлгийн багийн гишүүн, аэродром болон агаарын навигацийн үйлчилгээний байгууллагын ажилтан нь агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах байгууллагад агаарын хөлгийн осол, зөрчлийн талаарх анхан шатны болон дэлгэрэнгүй мэдээллийг холбогдох дүрэмд заасны дагуу өгөх үүрэгтэй.

40.2. Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах байгууллага осол, зөрчлийн мэдээллийг хүлээн авмагц шинжлэн шалгах ажиллагааг нэн даруй эхлүүлнэ.

40.3. Агаарын хөлөг өмчлөгч, эзэмшигч болон холбогдох бусад этгээд осол, зөрчилд өртсөн агаарын хөлөгтэй холбоотой эд мөрийн баримтыг шинжлэн шалгах ажиллагааг гүйцэтгэж дуусах хүртэл хадгалж, хамгаална.

40.4. Иргэн, нутгийн захиргааны байгууллага, онцгой байдлын болон цагдаагийн байгууллага Монгол Улсын нутаг дэвсгэрт агаарын хөлгийн осол, зөрчил гарсан үед шинжлэн шалгах байгууллагын үйл ажиллагааг явуулахад шаардлагатай туслалцааг цаг тухайд нь үзүүлэх үүрэгтэй.

41 дүгээр зүйл. Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааны зарчим

41.1. Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагаа нь осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилготой ба аливаа этгээдийн гэм бурууг тогтоох зорилгогүй байна.

41.2. Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагаа нь хараат бус, бие даасан байна.

41.3. Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага шаардлагатай гэж үзвэл шинжлэн шалгах ажиллагааг агаарын хөлөг бүртгэгч улс, агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ олгогч улс, агаарын хөлөг үйлдвэрлэгч улс, бүс нутгийн агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах байгууллагад хэсэгчлэн болон бүрэн шилжүүлж болно.

42 дугаар зүйл. Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах байгууллага

42.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт гарсан агаарын хөлгийн осол, зөрчлийг Конвенцын 13 дугаар хавсралтын дагуу шинжлэн шалгах, ангилах, бүртгэх ажиллагааг агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах байгууллага гүйцэтгэнэ.

42.2.Монгол Улсад бүртгэлтэй агаарын хөлөг тус улсын нутаг дэвсгэрийн гадна осол, ноцтой зөрчилд өртсөн үед шинжлэн шалгах ажиллагааг олон улсын гэрээний дагуу гүйцэтгэх ба Монгол Улсын нэрийн өмнөөс агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах байгууллага оролцож болно.

42.3.Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах байгууллага осол, зөрчилтэй холбоотой мэдээллийг цуглуулан дүн шинжилгээ хийж, шалтгаан нөхцөл, нөлөөлсөн хүчин зүйлсийн талаар тайлан гаргана.

42.4.Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгахчийг албан үүргээ гүйцэтгэсэнтэй нь холбогдуулан аливаа этгээдийн гэм бурууг тогтоох зорилгоор захиргааны болон иргэний, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх болон шүүн таслах ажиллагаанд гэрчээр оролцуулахыг хориглоно.

42.5.Энэ хуульд заасан шинжлэн шалгах ажиллагаа нь Шүүх шинжилгээний тухай хуулийн⁶ 4.1.1-д заасан үйл ажиллагаанд хамаарахгүй.

42.6.Шинжлэн шалгах багийг осол, зөрчил гарсан газарт ажиллахад шаардлагатай хамгаалах хувцас, хэрэгсэл, тоног төхөөрөмж, холбооны болон тээврийн хэрэгслээр хайгасан байна.

43 дугаар зүйл.Ерөнхий шинжлэн шалгагч, түүний бүрэн эрх

43.1.Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах байгууллагыг Ерөнхий шинжлэн шалгагч удирдана.

43.2.Ерөнхий шинжлэн шалгагч нь шинжлэн шалгах чиглэлээр мэргэшсэн, холбогдох хууль, Иргэний нисэхийн дүрэм, заавар, иргэний нисэхийн олон улсын эрх зүйн зохицуулалтын талаар зохих мэдлэгтэй Монгол Улсын иргэн байна.

43.3.Ерөнхий шинжлэн шалгахчийг 6 жилийн хугацаагаар томилно.

43.4.Ерөнхий шинжлэн шалгагч дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

43.4.1.агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах байгууллагын ажилтан, шинжлэн шалгахчийг томилох, чөлөөлөх;

43.4.2.агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах багийн ахлагч болон гишүүдийг томилох;

⁶ Шүүх шинжилгээний тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2023 оны 05 дугаарт нийтлэгдсэн.

43.4.3.агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааг зохион байгуулах;

43.4.4.ослын газрыг хамгаалалтад авах асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

43.4.5.шинжлэн шалгах ажиллагааны тайланг батлах;

43.4.6.агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах байгууллагын төсвийг хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах;

43.4.7.шинжлэн шалгах ажиллагаанд мөрдөх дотоод үйл ажиллагааны заавар, журмыг батлах.

44 дүгээр зүйл.Шинжлэн шалгагч, түүний бүрэн эрх

44.1.Шинжлэн шалгагч нь агаарын тээврийн нисгэгчийн үнэмлэхтэй нисгэгч, агаарын навигацийн болон агаарын хөлгийн инженер, эсхүл шинжлэн шалгах чиглэлээр мэргэшсэн нисэхийн бусад мэргэжилтэй байна.

44.2.Шинжлэн шалгагч дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

44.2.1.албан үүргээ гүйцэтгэхдээ агаарын хөлгийн осол, зөрчилтэй холбоотой барилга байгууламжид саадгүй нэвтрэх, холбогдох нотлох баримтыг гаргуулах;

44.2.2.шинжлэн шалгах ажиллагаанд шаардлагатай мэдээ, судалгаа, тодорхойлолт болон бусад нотлох баримтыг холбогдох хүн, хуулийн этгээдээс шаардан авах;

44.2.3.Ерөнхий шинжлэн шалгагчаас олгосон бусад эрх.

45 дугаар зүйл.Шинжлэн шалгах багийн ахлагч, түүний бүрэн эрх

45.1.Шинжлэн шалгах багийн ахлагч дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

45.1.1.агаарын хөлгийн осол, зөрчил болсон газарт саадгүй нэвтрэх, шинжлэн шалгах ажиллагаанд хамааралтай ослын үлдэгдэл, бүх төрлийн эд зүйлст хяналтаа тогтоох;

45.1.2.нислэгийн бичлэгийн төхөөрөмж, тухайн нислэгийн үйл ажиллагаатай холбоотой агаарын навигацийн үйлчилгээний бичлэг, бусад нотлох баримтыг өөрийн хяналтад авах;



45.1.3. шинжлэн шалгах ажиллагааны явцад эд мөрийн баримтыг хамгаалах, агаарын хөлөг, түүний үлдэгдэл байгаа бүсэд зөвшөөрөлгүй этгээд нэвтрэх, эд зүйлс үрэгдэж гэмтэх, алдагдахаас хамгаалах боломжит бүх арга хэмжээг авах;

45.1.4. ослын газрыг хамгаалалтад авах асуудлыг эрх бүхий байгууллагад хандаж шийдвэрлүүлэх;

45.1.5. шинжлэн шалгах ажиллагааг гүйцэтгэхэд шаардлагатай ажиглагч, оролцогчийг томилох;

45.1.6. шинжлэн шалгах ажиллагааны явцыг Ерөнхий шинжлэн шалгагчид танилцуулах, ослын боломжит шалтгаан, нөлөөлсөн байж болох хүчин зүйлд тулгуурлан аюулгүй байдлын зөвлөмж гаргах ажиллагааг зохион байгуулах;

45.1.7. ослын газрын хамгаалалтыг буулгах, цаашид шинжлэн шалгах ажиллагаанд шаардлагагүй болсон агаарын хөлөг, түүний бүрдэл хэсэг, эд зүйлсийг хадгалалтаас чөлөөлөх;

45.1.8. шинжлэн шалгах ажиллагааны тайлан гаргах;

45.1.9. хуульд заасан бусад.

46 дугаар зүйл. Шинжлэн шалгах ажиллагааны тайлан

46.1. Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах байгууллага тайланг гаргахаас өмнө шинжлэн шалгах ажиллагаанд хамааралтай байгууллага, хамтран оролцсон улс болон эрх бүхий байгууллагад тайлангийн төслийг хүргүүлж, саналыг нь авсан байна.

46.2. Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах байгууллага тайланг боломжит богино хугацаанд гаргаж, Ерөнхий шинжлэн шалгагчид хүргүүлж батлуулах бөгөөд баталсан тайланг нийтэд нээлттэй мэдээлнэ.

46.3. Агаарын хөлгийн осол, зөрчлийн шинжлэн шалгах ажиллагааны тайлан болон аюулгүй байдлын зөвлөмжийг аливаа этгээдийн гэм бурууг тогтоох, хэрэг хянан шийдвэрлэх болон шүүн таслах ажиллагаанд нотлох баримтаар ашиглахгүй.

47 дугаар зүйл. Аюулгүй байдлын зөвлөмж

47.1. Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах байгууллага шинжлэн шалгах ажиллагааны аль ч үе шатанд аюулгүй байдлын зөвлөмж гаргаж болно.

47.2. Аюулгүй байдлын зөвлөмжийг агаарын хөлөг үйлдвэрлэгч, иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, агаарын тээвэрлэгч болон бусад холбогдох байгууллагад, шаардлагатай бол Олон улсын иргэний нисэхийн байгууллагад хүргүүлнэ.

47.3. Аюулгүй байдлын зөвлөмжийг хүлээн авсан этгээд зөвлөмжийн дагуу шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэн 90 хоногийн дотор эргэж мэдэгдэх бөгөөд хэрэгжүүлэх боломжгүй бол үндэслэл бүхий тайлбарыг гаргаж хүргүүлнэ.

47.4. Энэ хуулийн 47.3-т заасан этгээд аюулгүй байдлын зөвлөмжийг хэсэгчлэн, эсхүл бүхэлд нь хүлээн зөвшөөрөхгүй байх бодит үндэслэл байгаа бол тайлбарыг агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах байгууллагад нэн даруй хүргүүлнэ.

48 дугаар зүйл. Шинжлэн шалгах ажиллагааг сэргээх

48.1. Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааны эцсийн тайлан гарсны дараа тайлангийн дүгнэлтийг өөрчилж болох баримт, нөхцөл байдал шинээр илэрсэн бол агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах байгууллага шинжлэн шалгах ажиллагааг сэргээнэ.

АРАВДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

49 дүгээр зүйл. Үйл ажиллагааны санхүүжилт

49.1. Иргэний нисэхийн хяналт, зохицуулалт, агаарын тээврийн эдийн засгийн зохицуулалт, агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагаа нь олон улсын гэрээний хэрэгжилтийг хангахуйц санхүүгийн чадавхтай байна.

50 дугаар зүйл. Иргэний нисэхэд ашиглах хэл

50.1. Иргэний нисэхэд ашиглах техник, технологийн баримт бичгийг монгол, англи хэлээр хэрэглэж болно.

50.2. Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээг англи хэлээр үзүүлж болно.



51 дүгээр зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

51.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хууль⁷ болон холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

51.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд үйлдлийн шинж чанараас хамааран Эрүүгийн хууль⁸, Зөрчлийн тухай хуульд⁹ заасан хариуцлага хүлээлгэнэ.

52 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

52.1.Энэ хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

⁷ Төрийн албаны тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2018 оны 01 дугаарт нийтлэгдсэн.

⁸ Эрүүгийн хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2016 оны 07 дугаарт нийтлэгдсэн.

⁹ Зөрчлийн тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2017 оны 24 дугаарт нийтлэгдсэн.



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 07 дугаар
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Зөрчлийн тухай хуулийн дараах хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/14.8 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг:

“1.Иргэний нисэхийн дүрэмд заасан баримт бичгийн бүрдэлгүй, эсхүл зохих зөвшөөрөлгүйгээр нисэхийн үйл ажиллагаа эрхэлсэн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж, хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Хуулиар эрх олгогдсон этгээд нисэхийн аюулгүй байдлын үзлэг шалгалтыг зохих журмын дагуу хийгээгүй бол үзлэг шалгалт хийх эрхийг нэг жил хүртэл хугацаагаар хасах, хуулийн этгээдийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

2/14.8 дугаар зүйлийн 4, 5 дахь хэсэг:

“4.Нислэгийг хэвээр үргэлжлүүлэх боломжгүй онцгой тохиолдлын талаар хүндэтгэх шалтгаангүйгээр мэдээлээгүй бол агаарын хөлгийн даргыг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

5.Иргэний нисэхийн хамгаалалттай бүсэд хууль бусаар нэвтэрсэн бол хүнийг нэг зуун нэгжээс нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

3/14.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг:

“1.Агаарын зайг нисэхэд ашиглах журам зөрчсөн бол агаарын хөлгийн даргыг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

4/14.9 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг:

“3.Агаарын зайн зөрчил үйлдсэн агаарын хөлгийн даргыг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 07 дугаар
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУльд ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.24 дэх заалтын “нислэгийн аюулгүй ажиллагааны хяналт хариуцсан байцаагч” гэснийг “иргэний нисэхийн хяналтын байцаагч” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Иргэний нисэхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Mongol Folio_02.html

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠎ᠠ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ
ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠎ᠠ

ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠎ᠠ
ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠎ᠠ
ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠎ᠠ
ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠎ᠠ

ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠎ᠠ
ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠎ᠠ
ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠎ᠠ
ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠎ᠠ

ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠎ᠠ
ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠎ᠠ



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 07 дугаар
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

АГААРЫН ЗАЙГ НИСЭХЭД АШИГЛАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Агаарын зайг нисэхэд ашиглах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтын “дээшхи хийн мандлын агаарын давхрагын” гэснийг “дээших агаар мандлын” гэж, мөн зүйлийн 4.2 дахь хэсгийн “Иргэний нисэхийн тухай хуулийн 3 дугаар зүйлд” гэснийг “Иргэний нисэхийн тухай хуулийн 5 дугаар зүйлд” гэж, 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийн “агаарын хаалгыг” гэснийг “агаарын хилийн орох, гарах цэгийг” гэж, мөн зүйлийн 6.4 дэх хэсгийн “агаарын хаалгыг Иргэний нисэхийн тухай хуулийн 7.1.3-т заасны дагуу тогтоох бөгөөд уг асуудлаар батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас санал авсан байна” гэснийг “орох, гарах цэгийг Иргэний нисэхийн тухай хуулийн 8.1.7-д заасны дагуу тогтооно” гэж, 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь заалтын “агаарын хаалгаар” гэснийг “агаарын хилийн орох, гарах цэгээр” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Иргэний нисэхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 07 дугаар
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ХИЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Монгол Улсын хилийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсгийн “агаарын хаалгаар” гэснийг “орох, гарах цэгээр” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Иргэний нисэхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Идэвхтэй Фолд_оа Нөдл

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠬᠢᠯᠢ ᠬᠡᠲᠡᠭᠦᠨ ᠬᠡᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ

ᠬᠡᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯᠡᠯ ᠬᠡᠲᠡᠭᠡᠨ
ᠬᠡᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯᠡᠯ ᠬᠡᠲᠡᠭᠡᠨ
ᠬᠡᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯᠡᠯ ᠬᠡᠲᠡᠭᠡᠨ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠬᠢᠯᠢᠨ ᠬᠡᠲᠡᠭᠡᠨ
ᠬᠡᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯᠡᠯ ᠬᠡᠲᠡᠭᠡᠨ ᠬᠡᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯᠡᠯ
ᠬᠡᠲᠡᠭᠡᠨ ᠬᠡᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯᠡᠯ ᠬᠡᠲᠡᠭᠡᠨ ᠬᠡᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯᠡᠯ
ᠬᠡᠲᠡᠭᠡᠨ ᠬᠡᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯᠡᠯ ᠬᠡᠲᠡᠭᠡᠨ ᠬᠡᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯᠡᠯ

ᠬᠡᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯᠡᠯ ᠬᠡᠲᠡᠭᠡᠨ ᠬᠡᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯᠡᠯ
ᠬᠡᠲᠡᠭᠡᠨ ᠬᠡᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯᠡᠯ ᠬᠡᠲᠡᠭᠡᠨ ᠬᠡᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯᠡᠯ
ᠬᠡᠲᠡᠭᠡᠨ ᠬᠡᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯᠡᠯ ᠬᠡᠲᠡᠭᠡᠨ ᠬᠡᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯᠡᠯ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠶ᠋ᠢᠨ ᠬᠢᠯᠢᠨ ᠬᠡᠲᠡᠭᠡᠨ
ᠬᠡᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯᠡᠯ ᠬᠡᠲᠡᠭᠡᠨ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 07 дугаар
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь төмөр замаар зорчигч, ачаа тээвэрлэх, төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангах, суурь бүтэц барих, суурь бүтэц болон хөдлөх бүрэлдэхүүн өмчлөх, эзэмших, ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Төмөр замын тээврийн хууль тогтоомж

2.1.Төмөр замын тээврийн хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль¹, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хууль Монгол Улсын нутаг дэвсгэрт төмөр замын тээвэртэй холбогдсон харилцааг өмчийн төрөл, хэлбэр харгалзахгүй зохицуулахад үйлчилнэ.

3.2.Метро, трамвай, соронзон болон тусгай загвар бүхий түүнтэй адилтгах нийтийн тээврийн төмөр замыг барих, ашиглахтай холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулахгүй.

4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“төмөр замын тээвэр” гэж төмөр замын тээвэрлэлт болон түүнд зориулагдсан суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүн, салбар зам, бусад байгууламж, тоног төхөөрөмж бүхий үйлдвэрлэл, угсралт, засвар, үйлчилгээний иж бүрдлийг;

¹ Монгол Улсын Үндсэн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1992 оны 01 дугаарт нийтлэгдсэн.

4.1.2.“төмөр замын тээвэрлэлт” гэж зорчигч, ачаа, тээш, ачаан тээшийг тээвэрлэхэд бэлтгэх, тээвэрлэх, тээвэрлэлтийг дуусгахтай холбоотой харилцан уялдаатай цогц ажил, үйлчилгээг;

4.1.3.“тээвэрлэгч” гэж тээвэрлэлтийн гэрээний дагуу төмөр замаар зорчигч, ачаа, тээш, ачаан тээшийг тээвэрлэх үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийг;

4.1.4.“төмөр замын суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч” гэж төмөр замын суурь бүтэц ашиглах тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийг;

4.1.5.“төмөр замын тээврийн байгууллага” гэж тээвэрлэгч, төмөр замын суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгчийг;

4.1.6.“төмөр замын суурь бүтэц” гэж төмөр замын дээд, доод бүтэц, гүүр, хоолой, өртөө, зерлөг, эрчим хүч, усан хангамж, дохиолол, холбоо, мэдээлэл, сүлжээ, техник, технологи бүхий инженерийн байгууламжийг;

4.1.7.“нийтийн төмөр зам” гэж нийтэд тээврийн үйлчилгээ үзүүлэх зориулалт бүхий төмөр замын суурь бүтцийг;

4.1.8.“үйлдвэрлэлийн зориулалттай төмөр зам” гэж аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд зориулагдсан төмөр замын суурь бүтцийг;

4.1.9.“салбар зам” гэж ачаа ачих, буулгах, хадгалах зам талбай болон бусад зориулалттай байгууламж бүхий төмөр замыг;

4.1.10.“хөдлөх бүрэлдэхүүн” гэж тээвэрлэлтэд ашиглаж байгаа зүтгүүр, ачааны болон зорчигчийн вагон, төмөр замаар явагч тусгай зориулалтын техник хэрэгслийг;

4.1.11.“галт тэрэг” гэж чиглэлийн дугаар, зүтгүүр бүхий хөдлөх бүрэлдэхүүнийг;

4.1.12.“зорчигч” гэж төмөр замаар зорчиж байгаа зорчих тасалбар, түүнтэй адилтгах баримт бичигтэй хүнийг;

4.1.13.“ачаа” гэж вагон, чингэлгээр тээвэрлэхээр зохих журмын дагуу хүлээн авсан эд зүйлсийг;

4.1.14.“аюултай ачаа” гэж төмөр замын тээвэрлэлт, ачилт, буулгалт, хадгалалтын явцад хүний эрүүл мэнд, мал, амьтан, хүрээлэн



байгаа орчинд хор хөнөөл учруулах, тээврийн хэрэгсэл, техник, тоног төхөөрөмж, барилга байгууламжид эвдрэл, гэмтэл үүсгэх, улмаар тэсэрч, дэлбэрэх, шатах шинж чанартай, үхэл, хордлого, түлэгдэлт, өвчин, осол үүсгэж болзошгүй химийн бодис, бүтээгдэхүүн, эд зүйлсийг;

4.1.15. “төмөр замын чиглэл” гэж төмөр замын эхлэл, төгсгөлийг тогтоосон байршлыг;

4.1.16. “төмөр замын суурь бүтцийн чиг” гэж төмөр замын чиглэлийн дагуух солбилцлын цэгүүдийг;

4.1.17. “төмөр замын цариг” гэж төмөр замын хос зам төмрийн дотор талын ажлын ирмэг хоорондын зайг;

4.1.18. “галт тэрэгний хөдөлгөөний зурмаг” гэж галт тэрэгний явах, өнгөрөх, ирэх хугацааг заасан технологийн хуваарийг;

4.1.19. “төмөр замын объект” гэж төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зурвас газар, суурь бүтэц, салбар зам, талбай, хөдлөх бүрэлдэхүүн болон техник, тоног төхөөрөмжийг;

4.1.20. “төмөр замын тээврийн аюулгүй байдал алдагдах” гэж төмөр замын технологийн горим зөрчигдсөнөөс хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, хүн, хуулийн этгээдийн өмчид хохирол учруулах осол, зөрчлийг;

4.1.21. “төмөр замын өртөө” гэж галт тэрэг хүлээн авах, явуулах, зөрүүлэх, зорчигчдод үйлчлэх, ачаа, тээш, ачаан тээшийг хүлээн авах, олгох болон сэлгээний хөдөлгөөнийг хэвийн гүйцэтгэх зам, төхөөрөмж, байгууламж бүхий төмөр замын суурь бүтцийн хэсгийг;

4.1.22. “төмөр замын гарам” гэж төмөр зам нь авто замтай ижил түвшинд огтлолцсон уулзварыг;

4.1.23. “тусгай зориулалтын багаж, хэрэгсэл” гэж төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангахад ашиглах багаж, хэрэгслийг;

4.1.24. “ачаан тээш” гэж хүн, хуулийн этгээдээс тээшийн вагоноор тээвэрлүүлэхээр зохих журмын дагуу хүлээлгэн өгсөн эд зүйлсийг;

4.1.25. “тээш” гэж тээшийн вагоноор тээвэрлүүлэхээр зохих журмын дагуу хүлээлгэн өгсөн зорчигчийн эд зүйлсийг.



5 дугаар зүйл.Төмөр замын тээвэрт баримтлах зарчим

5.1.Төмөр замын тээвэрт дараах зарчмыг баримтална:

5.1.1.хөдөлгөөний нэгдсэн зохицуулалттай, тээврийн бусад салбарын үйл ажиллагаатай уялдуулсан байх;

5.1.2.үйлчилгээний чанар, хүртээмж, аюулгүй байдлыг хангасан, тогтвортой байх;

5.1.3.зах зээлийн өрсөлдөөнт нөхцөлийг бий болгож, тэгш оролцоог хангасан байх.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ТАЛААРХ ТӨРИЙН ЗОХИЦУУЛАЛТ

6 дугаар зүйл.Улсын Их Хурлын бүрэн эрх

6.1.Улсын Их Хурал төмөр замын тээврийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6.1.1.төмөр замын тээврийн хууль тогтоомж батлах, түүний биелэлтийг хянан шалгах;

6.1.2.төмөр замын тээврийн талаарх олон улсын гэрээнд Монгол Улс нэгдэн орох, гарах асуудлыг шийдвэрлэх;

6.1.3.нийтийн төмөр замын чиглэл тогтоох;

6.1.4.энэ хуулийн 7.1.6-д заасан царигийн асуудлыг шийдвэрлэх.

7 дугаар зүйл.Засгийн газрын бүрэн эрх

7.1.Засгийн газар төмөр замын тээврийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.1.1.төмөр замын тээврийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтийг хангуулах, хяналт шалгалт хийх;

7.1.2.техник, эдийн засгийн судалгаанд үндэслэн төмөр замын суурь бүтцийн чиг тогтоох;



7.1.3.төмөр замын зурвас газрын ашиглах хугацааг тогтоох;

7.1.4.Монгол Улсын Хилийн тухай хуулийн² 26.1-д заасан хилийн зурваст төмөр замын суурь бүтэц барихтай холбоотой асуудлыг шийдвэрлэх;

7.1.5.үйлдвэрлэлийн зориулалттай төмөр замын чиглэл тогтоох;

7.1.6.нийтийн төмөр замын царигийн асуудлыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

7.1.7.хууль тогтоомжид заасан бусад эрх.

8 дугаар зүйл.Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

8.1.Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

8.1.1.төмөр замын тээврийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтийг хангах;

8.1.2.төмөр замын олон улсын хамтын ажиллагаанд Монгол Улсыг төлөөлөх;

8.1.3.төмөр замын тээврийн салбар дахь төрийн эзэмшлийн хувьцааны эрхийг төлөөлөх болон төрийн захиалгаар хийгдэх тээвэрлэлттэй холбоотой үйл ажиллагааг хууль, олон улсын гэрээнд заасны дагуу төрийг төлөөлөн хэрэгжүүлэх;

8.1.4.төмөр замын суурь бүтэц, салбар замын барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох, ашиглалтад оруулахтай холбоотой ажлыг зохион байгуулах;

8.1.5.энэ хуулийн 14.1.1, 14.1.2, 14.1.3, 14.1.4-т заасан тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох;

8.1.6.төмөр замын осол, зөрчлийг шинжлэн шалгах;

8.1.7.улс орны эдийн засаг, нийгэмд онцгой ач холбогдолтой зарим төрлийн ачаанд Засгийн газраас өгсөн чиглэлийн дагуу тээвэрлэлтийн давуу байдал олгох.

² Монгол Улсын хилийн тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2017 оны 06 дугаарт нийтлэгдсэн.

9 дүгээр зүйл. Аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрх

9.1. Аймаг, нийслэлийн Засаг дарга төмөр замын тээвэртэй холбоотой дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

9.1.1. тухайн нутаг дэвсгэрт орших төмөр замын зурвас газар, түүний гадна байрлах төмөр замын барилга байгууламжид нийгмийн хэв журам сахиулах ажлыг төмөр замын тээврийн байгууллагатай хамтран зохион байгуулах;

9.1.2. галт тэрэгний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажилтныг цэргийн албанд татахаас бусад Дайчилгааны тухай хуулийн³ 3.1.14-т заасан дайчилгаанд хамруулахгүй байх;

9.1.3. төмөр замын тээврийн аюулгүй байдал алдагдсаны улмаас учирсан хор уршгийг арилгахад шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал, мод, ус зэргийг ашиглуулах;

9.1.4. төмөр замын тээврийн аюулгүй байдал алдагдсаны улмаас учирсан хор уршгийг арилгахад Гамшгаас хамгаалах тухай хуулийн⁴ 32.1.9-д заасан үйл ажиллагааг зохион байгуулах;

9.1.5. төмөр замын бүтээн байгуулалттай холбоотой газар эзэмших, ашиглах эрх олгох, газар чөлөөлөх асуудлыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэх.

10 дугаар зүйл. Төмөр замын тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг

10.1. Төмөр замын тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага /цаашид “төрийн захиргааны байгууллага” гэх/ нь төмөр замын тээврийн үйл ажиллагаатай холбоотой хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг байна.

10.2. Төрийн захиргааны байгууллага нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

10.2.1. төмөр замын тээврийн хууль тогтоомж, дүрэм, журам, норм, стандарт боловсруулах, сурталчлах;

10.2.2. төмөр замын техник, технологитой холбоотой журам, аргачлал, горим, заавар, техникийн даалгавар, жагсаалт, загвар батлах;

³ Дайчилгааны тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1998 оны 06 дугаарт нийтлэгдсэн.

⁴ Гамшгаас хамгаалах тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2017 оны 07 дугаарт нийтлэгдсэн.

10.2.3.төмөр замын суурь бүтэц хооронд дамжуулах ачааны төрөл, хэмжээг тогтоох, хяналт тавих;

10.2.4.галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн зурмаг болон нэгдсэн технологийн горим батлах, суурь бүтэц хоорондын галт тэрэгний хөдөлгөөнийг захирамжлан зохион байгуулах;

10.2.5.төмөр замын суурь бүтцийн галт тэрэгний хөдөлгөөний удирдлагын төвийг нэгдсэн удирдлагаар хангах;

10.2.6.суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч хооронд болон суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч, тээвэрлэгч хооронд байгуулсан гэрээг шаардлагатай тохиолдолд хянаж, санал, дүгнэлт гаргаж хэрэгжилтийг хангуулах;

10.2.7.төмөр замын тээврийн тарифыг хянах, санал, дүгнэлт гаргах;

10.2.8.төмөр замын тээврийн үйл ажиллагаанд хууль тогтоомж болон дүрэм, журам, норм, стандарт, техникийн баримт бичгийн шаардлагыг хангаж байгаа эсэхэд хяналт шалгалт хийх, хэрэгжилтийг хангуулах;

10.2.9.төмөр замын тээврийн салбарын хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлох, мэргэжилтэй ажилтан сургах, давтан сургах, мэргэшүүлэх, мэргэшлийн зэрэг, хөдлөх бүрэлдэхүүн жолоодох эрх олгох;

10.2.10.төмөр замын тээврийн салбарт эрдэм шинжилгээ, судалгаа, шинжлэх ухаан технологи, инновацыг нэвтрүүлэх төлөвлөгөө, төсөл боловсруулж хэрэгжүүлэх;

10.2.11.төмөр замын суурь бүтэц, салбар зам, барилга байгууламжийг барих, өргөтгөх ажилд хяналт тавих;

10.2.12.хөдлөх бүрэлдэхүүнийг ашиглах талаар дүгнэлт гаргах, бүртгэх, дугаар, гэрчилгээ олгох;

10.2.13.төмөр замын суурь бүтэц, салбар замын хувийн хэрэг хөтлөх;

10.2.14.төмөр замын тээврийн статистик, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, дүн шинжилгээ хийх, эрх бүхий байгууллагад мэдээлэх;

10.2.15.төмөр замын зураг төсөлд магадлал хийх ажлыг зохион байгуулж хүн, хуулийн этгээдийг сонгон шалгаруулах, шинжээчийн эрх олгох;

10.2.16.төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангах, гэрчилгээ олгохтой холбоотой үйл ажиллагааг зохион байгуулах.

10.3.Улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч, улсын байцаагч нь энэ хуулийн 10.2.8-д заасан хяналт шалгалтыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн хэрэгжүүлнэ.

10.4.Энэ хуулийн 10.3-т заасан байцаагчийн эрхийг төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олгоно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ДҮРЭМ, ЖУРАМ, ТОХИРЛЫН ҮНЭЛГЭЭ

11 дүгээр зүйл.Төмөр замын тээврийн дүрэм, журам

11.1.Төмөр замын тээврийн салбарт дараах дүрэм, журам, аргачлал, нормыг баталж мөрдүүлнэ:

11.1.1.төмөр замын техник ашиглалтын дүрэм;

11.1.2.төмөр замаар ачаа тээвэрлэх дүрэм;

11.1.3.төмөр замаар зорчигч, тээш, ачаан тээш тээвэрлэх дүрэм;

11.1.4.галт тэрэгний хөдөлгөөний удирдлагын журам;

11.1.5.төмөр замын барилга байгууламжийн ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах журам;

11.1.6.төмөр замын техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах, магадлал хийх, техник, технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээний журам;

11.1.7.төмөр замын тээврийн осол, зөрчлийг шинжлэн шалгах журам;

11.1.8.төмөр замын дохиолол, холбооны журам;

11.1.9.галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн зурмаг зохицуулалтын журам;

11.1.10.төмөр замын тээврийн зориулалттай газарт объект байрлуулах, үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах, нэвтрэх журам;

11.1.11.хөдлөх бүрэлдэхүүн ашиглах журам;

11.1.12.Монгол Улсын хилээр хөдлөх бүрэлдэхүүн нэвтрүүлэх, бүртгэх, гэрчилгээ олгох журам;



11.1.13.галт тэрэгний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажилтны хөдөлмөр эрхлэлтийн харилцаа, нөхцөл, сахилгын тусгай журам;

11.1.14.төмөр замын гарам ашиглах журам;

11.1.15.төмөр замын тээвэрт тусгай зориулалтын багаж, хэрэгсэл ашиглах журам;

11.1.16.төмөр замын тээврийн мэдээлэл бүртгэх, солилцох журам;

11.1.17.төмөр замын тээврийн салбарын мэргэжилтэй ажилтан сургах, давтан сургах, мэргэшүүлэх, мэргэшлийн зэрэг болон хөдлөх бүрэлдэхүүн жолоодох эрх олгох журам;

11.1.18.төмөр замын тээврийн байгууллагын ажилтны албаны хувцас хэрэглэх журам;

11.1.19.төмөр замын суурь бүтэц, салбар замын үйлчилгээ үзүүлэх, тэдгээрийг ашиглах журам;

11.1.20.төмөр замын тээврийн тариф тогтоох аргачлал;

11.1.21.төмөр замын барилга байгууламжийн ажлын төсвийн суурь норм;

11.1.22.тусгай тээвэрлэлтийн журам;

11.1.23.төмөр замаар аюултай ачаа тээвэрлэх, ачиж буулгах, хадгалах журам;

11.1.24.Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, гадаад улсын төрийн тэргүүний зорчих тусгай галт тэрэгний аялах журам;

11.1.25.Төмөр замын техникийн баримт бичиг, норм, стандартын сангийн эх үүсвэрийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам;

11.1.26.төмөр замын ажилтанд эрүүл мэндийн үзлэг хийх журам;

11.1.27.төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой объект, үйл ажиллагаанд гэрчилгээ олгох журам.

11.2.Энэ хуулийн 11.1.1, 11.1.2, 11.1.3-т заасан дүрэм, 11.1.4, 11.1.5, 11.1.7, 11.1.8, 11.1.9, 11.1.12, 11.1.14, 11.1.17, 11.1.25, 11.1.27-д заасан журам, 11.1.20-д заасан аргачлал, 11.1.21-д заасан нормыг төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, энэ хуулийн



11.1.6, 11.1.10, 11.1.11, 11.1.13, 11.1.16, 11.1.18, 11.1.19-д заасан журмыг төрийн захиргааны байгууллага тус тус батална.

11.3.Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн энэ хуулийн 11.1.22, 11.1.23-т заасан журмыг тагнуулын байгууллагатай, энэ хуулийн 11.1.24-т заасан журмыг төрийн тусгай хамгаалалтын байгууллагатай, энэ хуулийн 11.1.26-д заасан журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй тус тус хамтран батална.

11.4.Энэ хуулийн 11.1.15-д заасан журмыг төрийн захиргааны байгууллага тагнуулын байгууллагатай хамтран батална.

12 дугаар зүйл.Төмөр замын тээврийн стандарт, тохирлын үнэлгээ

12.1.Төмөр замын тээврийн стандарт, тохирлын үнэлгээтэй холбогдсон харилцааг энэ хууль болон Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулиар⁵ зохицуулна.

12.2.Төмөр замын тээвэрт ашиглагдах хэмжилт, оношлогооны багаж, техник, хэрэгслийн баталгаажуулалтыг Хэмжил зүйн тухай хуулиар⁶ зохицуулна.

13 дугаар зүйл.Төмөр замын техникийн баримт бичиг, норм, стандартын сан

13.1.Төмөр замын техникийн баримт бичиг, норм, стандартыг боловсруулах, хэвлэж олшруулах, сурталчлах болон эдгээрийг зохион байгуулах зориулалт бүхий сан /цаашид “сан” гэх/-тай байна.

13.2.Сан нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

13.2.1.төмөр замын суурь бүтцийг барих, өргөтгөх, шинэчлэх, зураг төсөл боловсруулах ажлын төсөвт өртгийн 0.4 хувиар тооцсон орлого;

13.2.2.төмөр замын техникийн баримт бичиг, норм борлуулсны орлого;

13.2.3.төмөр замын техникийн баримт бичиг, норм, стандартыг боловсронгуй болгох зорилгоор өгсөн хандив.

⁵ Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2018 оны 10 дугаарт нийтлэгдсэн.

⁶ Хэмжил зүйн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2019 оны 24 дугаарт нийтлэгдсэн.



13.3.Төмөр замын техникийн баримт бичиг, норм, стандартын сангийн эх үүсвэрийг бүрдүүлэх, зарцуулах үйл ажиллагааг төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 11.1.25-д заасан журмын дагуу зохион байгуулна.

14 дүгээр зүйл.Төмөр замын тусгай зөвшөөрөл

14.1.Төмөр замын тусгай зөвшөөрөл дараах төрөлтэй байна:

14.1.1.төмөр замын суурь бүтэц барих, зураг төсөл боловсруулах, техник, технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээ;

14.1.2.төмөр замын суурь бүтэц ашиглах;

14.1.3.төмөр замын суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүн, тэдгээрийн эд анги үйлдвэрлэх, угсрах, засварлах;

14.1.4.төмөр замын тээвэрлэгчийн үйл ажиллагаа эрхлэх.

14.2.Зөвшөөрөл хүсэгч нь Зөвшөөрлийн тухай хуулийн⁷ 5.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан баримт бичгээс гадна энэ хуулийн 14.3-т заасан нөхцөл, шаардлага хангасныг нотолсон баримт бичгийг төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

14.3.Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 5.1, 5.4, 5.6, 5.7-д заасан тусгай зөвшөөрөл хүсэгчид тавих нөхцөл, шаардлагыг төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

14.4.Энэ хуулийн 14.1.2, 14.1.4-т заасан тусгай зөвшөөрлийг нэг хуулийн этгээдэд давхардуулан олгохыг хориглоно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ЗОРИУЛАЛТТАЙ ГАЗАР

15 дугаар зүйл.Төмөр замын тээврийн зориулалттай газар

15.1.Төмөр замын тээврийн зориулалттай газарт тусгай бүс, зурвас газар, хамгаалалтын бүс хамаарна.

15.2.Энэ хуулийн 15.1-д заасан газрын хэмжээг стандартаар тогтооно.

15.3.Төмөр замын тээврийн зориулалттай газарт объект байрлуулах, үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах, нэвтрэхтэй холбогдсон харилцааг энэ хуулийн 11.1.10-т заасан журмаар зохицуулна.

⁷ Зөвшөөрлийн тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2022 оны 38 дугаарт нийтлэгдсэн.

16 дугаар зүйл.Төмөр замын тусгай бүс

16.1.Галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөн, ачилт, буулгалтын ажил гүйцэтгэдэг тусгай тэмдэг, тэмдэглэгээ бүхий дэвсгэр газрыг төмөр замын тусгай бүс гэнэ.

16.2.Төмөр замын тусгай бүсэд энэ хуулийн 11.1.10-т заасан журамд тусгагдсанаас бусад үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

17 дугаар зүйл.Төмөр замын зурвас газар

17.1.Төмөр замын дагуух технологийн үйл ажиллагааг явуулах, тээврийн аюулгүй байдлыг хангах газрыг төмөр замын зурвас газар гэнэ.

17.2.Төмөр замын зурвас газар нь төрийн өмч байна.

17.3.Төмөр замын зурвас газарт төмөр замын тээврийн үйл ажиллагаанаас бусад үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхийг хориглоно.

18 дугаар зүйл.Төмөр замын хамгаалалтын бүс

18.1.Төмөр замын суурь бүтцийг гадны сөрөг хүчин зүйл, болзошгүй эрсдэлээс сэргийлэх, төмөр замын тээврийн аюулгүй байдал алдагдах, хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөө үзүүлэхээс хамгаалах зориулалт бүхий хэсэгчилсэн хамгаалалтын бүстэй байж болно.

19 дүгээр зүйл.Төмөр замын цариг

19.1.Монгол Улсын төмөр замын сүлжээ, түүнд холбогдох буюу огтлолцох төмөр замын цариг ижил байна.

19.2.Хил дамнасан төмөр замын царигийн асуудлыг олон улсын гэрээ, хэлэлцээрт нийцүүлэн шийдвэрлэнэ.

19.3.Энэ хуулийн 19.1, 19.2-т зааснаас бусад тохиолдолд царигийн асуудлыг Улсын Их Хурал шийдвэрлэнэ.

ТАВДУГААР БҮЛЭГ ТӨМӨР ЗАМЫН СҮЛЖЭЭ, СУУРЬ БҮТЦИЙН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ

20 дугаар зүйл.Төмөр замын сүлжээ

20.1.Тээвэрлэлтийн төлөвлөлт, зохицуулалтын нэгдмэл системтэй, харилцан холбогдсон төмөр замын суурь бүтцүүдийг төмөр замын сүлжээ гэнэ.

20.2.Төмөр замын суурь бүтцүүдийг холбоход дараах шаардлагыг хангана:

20.2.1.галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалт нэгдмэл, төвлөрсөн байх;

20.2.2.зорчигч, ачаа тээвэрлэлтийн нэгдсэн бичиг баримттай байх;

20.2.3.цахим мэдээлэл солилцох нэгдмэл технологи, сүлжээтэй байх.

20.3.Төмөр замын сүлжээний төлөвлөлтөд дараах хүчин зүйлийг харгалзана:

20.3.1.улсын нийгэм, эдийн засаг болон бүс нутгийн хөгжлийн бодлого;

20.3.2.хүн амын суурьшил, хот, суурин газрын байршил, ирээдүйн хөгжлийн төлөв;

20.3.3.ашигт малтмалын орд газрын байршил, нөөц, түүнийг ашиглах боломж;

20.3.4.олон улсын болон хил орчмын бүс нутгийн хамтын ажиллагааны хэтийн төлөв;

20.3.5.аялал жуулчлалыг хөгжүүлэх нөхцөл, аялал жуулчлалын газар, нөөц газар, амралт, сувиллын газрын бүс нутгийн байршил;

20.3.6.эрчим хүч, холбоожуулалтын нэгдсэн тогтолцоо, тэдгээрийн хөгжлийн хэтийн төлөв;

20.3.7.газрын гадаргын хэв шинж, газар зүйн байршил, бартаажилт, инженер-геологийн нөхцөл;

20.3.8.тусгай хамгаалалтай газар нутгийн байршил, ирээдүйн төлөв.

21 дүгээр зүйл.Төмөр замын суурь бүтцийн зураг төсөл

21.1.Төмөр замын суурь бүтцийн зураг төсөл нь төмөр замын суурь бүтцийг барих, засварлахад шаардагдах техник, эдийн засгийн үндэслэл, геологийн дүгнэлт, ус зүйн судалгаа, геодезийн хэмжилтийн тайлан, археологи, палеонтологийн судалгаа, байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, судалгаа, инженерийн тооцоо, нарийвчилсан зураг, төсөв, техникийн шаардлага зэргээс бүрдэнэ.

21.2.Монгол Улсын нутаг дэвсгэр дээр байгуулах төмөр замын суурь бүтцийн зураг төслийг гадаадын хуулийн этгээд боловсруулах тохиолдолд Монгол Улсын тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдтэй хамтран гүйцэтгэнэ.

21.3.Төмөр замын суурь бүтцийн зураг төслийг Монгол Улсын эрх бүхий этгээдээр магадлуулсан байна.

21.4.Төмөр замын техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах, магадлал хийх, техник, технологийн хяналт тавихтай холбогдсон харилцааг энэ хуулийн 11.1.6-д заасан журмаар зохицуулна.

22 дугаар зүйл.Төмөр замын суурь бүтцийн барилгын ажил

22.1.Төмөр замын суурь бүтцийн барилгын ажлыг тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд захиалагчтай байгуулсан гэрээний үндсэн дээр холбогдох хууль тогтоомж, төмөр замын тээврийн дүрэм, журам, техникийн зохицуулалт, стандартын дагуу барьж гүйцэтгэнэ.

22.2.Төмөр замын суурь бүтцийн барилгын ажлын техник, технологийн хяналтыг эрх бүхий мэргэжлийн байгууллага, захиалагчтай гэрээ байгуулсны үндсэн дээр хэрэгжүүлнэ.

23 дугаар зүйл.Төмөр замын суурь бүтцийг ашиглалтад оруулах

23.1.Төмөр замын суурь бүтцийг ашиглалтад оруулах ажиллагааг энэ хуулийн 11.1.5-д заасан журмаар зохицуулна.

23.2.Ашиглалтад оруулах төмөр замын суурь бүтэц нь холбогдох хууль, төмөр замын тээврийн дүрэм, журам, техникийн баримт бичиг, норм, стандартын шаардлагыг бүрэн хангасан байна.

23.3.Захиалагч нь төмөр замын суурь бүтцийг улсын комисс ажиллахаас өмнө дараах үүрэг бүхий техникийн комиссыг томилон ажиллуулна:

23.3.1.батлагдсан зураг төсөл, төсөв болон түүнд оруулсан өөрчлөлтийн дагуу баригдсан, суурилуулагдсан эсэхийг шалгах;

23.3.2.гүйцэтгэлийн зураг төслийн дагуу хийгдсэн эсэхийг шалгах;

23.3.3.суурь бүтэц, түүний бүрдлийг шалгах, турших, акт, баримт, тайлан бүрдүүлж дүгнэлт гаргах.

23.4.Захиалагч нь төмөр замын суурь бүтцийг ашиглалтад оруулахад дараах баримт бичгийг бүрдүүлнэ:

23.4.1.суурь бүтцийн барилгын ажлын үе шатны гүйцэтгэлийн тайлан;

23.4.2.барилгын ил, далд ажлын акт;

23.4.3.зураг төсөл зохиогчийн хяналтын нэгдсэн дүгнэлт;

23.4.4.захиалагчийн техникийн хяналтын нэгдсэн дүгнэлт;

23.4.5.суурь бүтцийн инженерийн шугам сүлжээний холболтыг техникийн нөхцөлийн дагуу гүйцэтгэснийг баталгаажуулсан тэмдэглэл, холбогдох мэдээлэл;

23.4.6.суурь бүтцэд хийгдсэн хийц, бүтээцийн шинжтэй өөрчлөлтийн зураг төсөл, түүний зохиогчийн зөвшөөрөл, магадлалын дүгнэлт;

23.4.7.суурь бүтцийн гүйцэтгэлийн зураг;

23.4.8.техникийн комиссын үүрэг даалгаврын биелэлт;

23.4.9.суурь бүтцийн бүрдэл хэсгийн тоног төхөөрөмж угсарсан акт, холбогдох байгууллагаар баталгаажуулсан тоног төхөөрөмжийн туршилтын баримт бичиг, тоног төхөөрөмжийг зааврын дагуу суурилуулсан эсэхэд хийсэн туршилтын дүгнэлт;

23.4.10.техник ашиглалтын түвшин тогтоох шалгалтын дүгнэлт;

23.4.11.бусад холбогдох баримт бичиг.

23.5.Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 23.4-т заасан баримт бичиг нь шаардлага хангасан тохиолдолд төмөр замын суурь бүтцийг байнгын ашиглалтад хүлээн авах улсын комиссыг томилно.

23.6.Энэ хуулийн 23.2-т заасан шаардлага хангасан төмөр замын суурь бүтцийг өртөө, зөрлөг хооронд хэсэгчлэн ашиглалтад оруулж болно.

23.7.Энэ хуулийн 23.6-д заасны дагуу төмөр замын суурь бүтцийг хэсэгчлэн ашиглалтад оруулахтай холбогдсон харилцааг энэ хуулийн 11.1.5-д заасан журмаар зохицуулна.

23.8.Ашиглалтад оруулаагүй төмөр замаар хүн тээвэрлэх, зорчигчийн галт тэрэг аялуулахыг хориглоно.



24 дүгээр зүйл.Төмөр замын суурь бүтцийн өмчлөл

24.1.Нийтийн төмөр зам нь төрийн өмчит буюу төрийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн өмчлөлд байна.

24.2.Улсын хилийн боомт чиглэсэн, хил дамнасан төмөр зам нь нийтийн төмөр замд хамаарах бөгөөд энэ төмөр замын өмчлөгч нь нэг хуулийн этгээд байна.

24.3.Төмөр замын суурь бүтцийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр барих тохиолдолд суурь бүтцийг төрийн өмчлөлд шилжүүлэх хугацаа, нөхцөлийг түншлэлийн гэрээнд тусгах бөгөөд түншлэлийн хугацаанд суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч нь тээвэрлэгчийн үйл ажиллагаа эрхэлж болно.

24.4.Үйлдвэрлэлийн зориулалттай төмөр зам нь өмчийн аль ч хэлбэртэй байж болно.

25 дугаар зүйл.Төмөр замын суурь бүтцийн үйлчилгээ

25.1.Төмөр замын суурь бүтцийн үйлчилгээнд дараах үйлчилгээ хамаарна:

25.1.1.галт тэрэгний хөдөлгөөнийг диспетчерийн удирдлагаар хангах;

25.1.2.хөдлөх бүрэлдэхүүнийг сэлгэх, найруулах;

25.1.3.хөдлөх бүрэлдэхүүнд зэхэлт /эрчим хүч, түлш, шатахуун, ус, хийгээр хангах/ хийх;

25.1.4.хөдлөх бүрэлдэхүүнд техникийн үзлэг, үйлчилгээ хийх;

25.1.5.аюултай, овор ихтэй, хамгаалалттай ачаатай хөдлөх бүрэлдэхүүн, хүнд жинтэй болон урт бүрэлдэхүүнтэй галт тэргэнд хяналт тавих;

25.1.6.галт тэрэгний хөдөлгөөнтэй холбоотой мэдээлэл солилцох, мэдээллээр хангах;

25.1.7.төмөр замын тээврийн ашиглалттай холбоотой дохиолол холбоо, мэдээлэл, сүлжээ, программ хангамжаар хангах.

26 дугаар зүйл.Төмөр замын суурь бүтцийн үйлчилгээнд тавих шаардлага

26.1.Төмөр замын суурь бүтцийн үйлчилгээнд дараах шаардлагыг тавина:



26.1.1.төмөр замын суурь бүтцийн үйлчилгээ нь төмөр замын тээврийн аюулгүй байдал, техникийн баримт бичиг, стандартын шаардлагад нийцсэн байх;

26.1.2.суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгчид галт тэрэг харилцан чөлөөтэй нэвтрэх нөхцөлийг тусгасан гэрээ байгуулсан байх;

26.1.3.төмөр замын суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч болон тээвэрлэгч нь энэ хуулийн 25.1-д заасан үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулсан гэрээ байгуулсан байх;

26.1.4.төмөр замын суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч нь галт тэрэгний хөдөлгөөний удирдлагын төвтэй байх;

26.1.5.төмөр замын суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч нь тухайн суурь бүтцийн хүчин чадлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн өргөтгөл, шинэчлэлийн хөрөнгө оруулалт, санхүүжилтийн хөтөлбөрийг агуулсан дунд хугацааны бизнес төлөвлөгөөтэй байх.

26.2.Галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн зурмаг, нэгдсэн технологийн горимыг энэ хуулийн 11.1.9-д заасан журмаар зохицуулна.

26.3.Төмөр замын суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч нь суурь бүтцийн үйлчилгээг тэгш эрхийн зарчмыг баримтлан гэрээний үндсэн дээр нийтэд үзүүлнэ.

26.4.Төмөр замын суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч нь үйлчилгээ үзүүлэхээс үндэслэлгүйгээр татгалзах, бусдад давуу байдал олгох, тээвэрлэлтийн үйл ажиллагаанд саад учруулах, өрсөлдөөнийг хязгаарлахыг хориглоно.

26.5.Төмөр замын суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч болон тээвэрлэгч нь тусдаа хуулийн этгээд байна.

26.6.Энэ хуулийн 26.1.2, 26.1.3-т заасан гэрээний үлгэрчилсэн загварыг энэ хуулийн 11.1.19-д заасан журмаар батална.

27 дугаар зүйл.Төмөр замын суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгчийн эрх, үүрэг

27.1.Төмөр замын суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч нь дараах эрхтэй:

27.1.1.төмөр замын суурь бүтцийн төлбөртэй үйлчилгээ үзүүлэх;

27.1.2.өөрийн төмөр замын суурь бүтэц дэх галт тэрэгний хөдөлгөөний зурмаг батлах, хөдөлгөөний нэгдсэн зурмагт санал өгөх;

27.1.3.тээвэрлэгчийн тээвэрлэлтийн технологи, хөдлөх бүрэлдэхүүний техникийн үзүүлэлт, техникийн байдал нь төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангахгүй, суурь бүтцийн хүчин чадлаас хэтэрсэн тохиолдолд суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэхээс татгалзах;

27.1.4.энэ хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм, журам, стандартад нийцүүлэн дотооддоо үйлчлэх техник, технологийн дүрэм, журам, зааврыг баталж мөрдүүлэх;

27.1.5.өөрийн төмөр замын суурь бүтцийг шинэчлэх, засварлах, өргөтгөх ажлыг гүйцэтгэх зорилгоор галт тэрэгний хөдөлгөөнийг хязгаарлах, түр хаах.

27.2.Төмөр замын суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч нь дараах үүрэгтэй:

27.2.1.төмөр замын тээврийн болон холбогдох бусад хууль тогтоомж, төмөр замын тээврийн дүрэм, журам, техникийн баримт бичиг, норм, стандартыг дагаж мөрдөх;

27.2.2.энэ хуулийн 26.1.2, 26.1.3-т заасан гэрээ байгуулах;
27.2.3.галт тэрэгний хөдөлгөөнийг нэгдсэн зурмагт нийцүүлэн зохион байгуулах;

27.2.4.салбар зам эзэмшигчтэй гэрээ байгуулж, сэлгээний хөдөлгөөнийг зохион байгуулах;

27.2.5.төмөр замын суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай мэргэжлийн ажилтантай байх;

27.2.6.төмөр замын тээврийн аюулгүй байдал, тасралтгүй, хэвийн үйл ажиллагааг хангах;

27.2.7.энэ хуулийн 11.1.16-д заасан журмын дагуу шаардлагатай мэдээ, тайланг эрх бүхий байгууллагад хүргүүлэх;

27.2.8.энэ хуулийн 27.1.5-д заасны дагуу галт тэрэгний хөдөлгөөнийг хязгаарласан, түр хаасан тохиолдолд нийтэд мэдээлэх;

27.2.9.үйлдвэрлэлийн зориулалттай төмөр замын суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч нь гэрээний үндсэн дээр суурь бүтцийн үйлчилгээг нийтэд үзүүлэх.



27.3.Төмөр замын суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч нь өөрийн бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний стандарт, тохирлын үнэлгээний хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих эрх бүхий нэгжтэй байна.

28 дугаар зүйл.Төмөр замын суурь бүтцийн хувийн хэрэг

28.1.Төмөр замын суурь бүтэц нь гүйцэтгэлийн зураг төсөл, төсөв, барилгын ил, далд ажлын акт, суурь бүтэц барих ажлын явцын баримт бичиг, чанарт холбогдох эрх бүхий байгууллагын акт, дүгнэлт, магадлалын ерөнхий дүгнэлт, ашиглалтад хүлээлгэн өгсөн баримт бичгээс бүрдсэн хувийн хэрэгтэй байна.

28.2.Төмөр замын суурь бүтэц өмчлөгч, эзэмшигч нь суурь бүтцийн хувийн хэргийг төмөр замын тээврийн статистик, мэдээллийн нэгдсэн санд бүртгүүлнэ.

29 дүгээр зүйл.Төмөр замын суурь бүтцийн хөдөлгөөнийг нээх, хаах

29.1.Төмөр замын суурь бүтцийн хөдөлгөөнийг нээх, хаах асуудлыг энэ хуулийн 11.1.19-д заасан журмаар зохицуулна.

29.2.Олон улсын тээвэрт төмөр замын чиглэлийг нээх, хаах асуудлыг олон улсын гэрээ, хэлэлцээрийн дагуу гүйцэтгэнэ.

30 дугаар зүйл.Төмөр замын суурь бүтэц, түүний эд ангийг үйлдвэрлэх, угсрах, засварлах

30.1.Төмөр замын суурь бүтэц, түүний эд ангийг үйлдвэрлэх, угсрах, засварлах ажлыг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр гүйцэтгэнэ.

31 дүгээр зүйл.Төмөр замын суурь бүтцийг бусад дэд бүтэц, байгууламжтай уялдуулах

31.1.Төмөр замын суурь бүтцийг шинээр барих, шинэчлэн сайжруулахад авто зам болон бусад төрлийн суурь бүтэцтэй ижил түвшинд огтлолцуулахгүй, ашиглаж байгаа төмөр замын суурь бүтцийн чиг, хэвгийг өөрчлөхгүй байна.

31.2.Төмөр замын суурь бүтэц нь энэ хуулийн 31.1-д зааснаас бусад дэд бүтэцтэй огтлолцох тохиолдолд төрийн захиргааны байгууллагаас зөвшөөрөл авна.

31.3.Төмөр замын тээврийн зориулалттай газарт баригдах хий, газрын тос дамжуулах хоолой, инженерийн шугам сүлжээ, авто зам,

барилга байгууламж нь төмөр замын сүлжээний төлөвлөлттэй уялдсан байна.

31.4.Төмөр замын суурь бүтэцтэй ижил бус түвшинд огтлолцох авто зам болон бусад төрлийн суурь бүтцийн зураг төслийг боловсруулахдаа төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөнө.

Тайлбар:Энэ хуулийн 31.1-д заасан “бусад төрлийн суурь бүтэц” гэж метро, трамвай, соронзон болон тусгай загвар бүхий түүнтэй адилтгах нийтийн тээврийн төмөр замыг ойлгоно.

32 дугаар зүйл.Салбар замын үйлчилгээ

32.1.Салбар замын үйлчилгээнд ачаа ачих, буулгах, сэлгээний хөдөлгөөн хийх, ачаа хүлээн авах, олгох, хадгалах, шилжүүлэх зэрэг үйл ажиллагаа хамаарна.

32.2.Салбар замын үйлчилгээтэй холбогдсон харилцааг энэ хуулийн 11.1.19-д заасан журмаар зохицуулна.

32.3.Салбар замыг холбох, өргөтгөх, салаалахтай холбоотой асуудлыг төмөр замын суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгчийн саналыг харгалзан төрийн захиргааны байгууллага шийдвэрлэнэ.

32.4.Салбар зам, түүний байгууламж, төхөөрөмж, ачаа ачих, буулгах зам, талбай нь галт тэрэгний хөдөлгөөний болон хөдөлмөрийн аюулгүй байдлын шаардлага, төмөр замын тээврийн холбогдох дүрэм, журам, техникийн баримт бичиг, норм, стандартын шаардлагыг хангасан байна.

32.5.Салбар зам эзэмшигч болон төмөр замын суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч, тээвэрлэгч хоорондын харилцааг тэдгээрийн хооронд байгуулсан гэрээгээр зохицуулна.

32.6.Салбар зам нь зам болон ачих, буулгах тоног төхөөрөмжийн техникийн паспорт, замын дагуу огтлолцлын гүйцэтгэлийн зураг, хиймэл төхөөрөмжийн зураг, эрх бүхий байгууллагын дүгнэлт, байнгын ашиглалтад хүлээж авсан болон ашиглалтын явцын засвар үйлчилгээний талаарх баримт бичгээс бүрдсэн хувийн хэрэг хөтөлнө.

32.7.Салбар зам эзэмшигч нь хүн, хуулийн этгээдэд салбар замын үйлчилгээ үзүүлэхээс үндэслэлгүй татгалзах, өөрийн салбар замаар дамжин холбогдож байгаа бусад салбар зам эзэмшигчийн үйл ажиллагаанд саад учруулах, давуу байдал олгохыг хориглоно.



ЗУРГАДУГААР БҮЛЭГ ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВЭРЛЭЛТ

33 дугаар зүйл.Төмөр замын тээвэрлэлтийн төрөл

33.1.Төмөр замын тээвэрлэлт дараах төрөлтэй байна:

- 33.1.1.зорчигч, тээш, ачаан тээш тээвэрлэлт;
- 33.1.2.ачаа тээвэрлэлт;
- 33.1.3.тусгай тээвэрлэлт.

33.2.Төмөр замаар зорчигч тээвэрлэх харилцааг энэ хуулийн 11.1.3-т заасан, ачаа тээвэрлэх харилцааг энэ хуулийн 11.1.2-т заасан дүрмээр, тусгай тээвэрлэлт хийх харилцааг энэ хуулийн 11.1.22-т заасан журмаар зохицуулна.

34 дүгээр зүйл.Тээвэрлэгчид тавих шаардлага

34.1.Тээвэрлэгч нь дараах шаардлагыг хангасан байна:

34.1.1.төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхлэхэд шаардлагатай мэргэжлийн ажилтантай байх;

- 34.1.2.зүтгүүртэй байх;
- 34.1.3.вагонтой байх;
- 34.1.4.салбар замтай байх;
- 34.1.5.засвар, үйлчилгээний газартай байх.

34.2.Тээвэрлэгч нь энэ хуулийн 34.1.2, 34.1.4, 34.1.5-д заасныг түрээсийн, эсхүл ашиглалтын гэрээгээр хэрэгжүүлж болно.

34.3.Тээвэрлэгч нь гэрээний дагуу суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүн ашиглах, тээвэрлэлтийг зохион байгуулах эрхтэй.

34.4.Тээвэрлэгч нь энэ хуулийн 26.1.3-т заасан суурь бүтцийн үйлчилгээний гэрээ байгуулах, хөдлөх бүрэлдэхүүний техникийн болон ашиглалтын аюулгүй байдлыг хангах, шударга бус өрсөлдөөнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хүн, хуулийн этгээдэд давуу байдал олгохгүй байх үүрэг хүлээнэ.

34.5.Тээвэрлэгч нь төмөр замын ачаа эргэлт, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх дунд хугацааны төлөвлөгөөтэй байна.

34.6.Тээвэрлэгч нь өөрийн бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний стандарт, тохирлын үнэлгээний хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих эрх бүхий нэгжтэй байна.



34.7.Тээвэрлэгч нь тээвэрлэлтийн явцад ачаа илгээгч, хүлээн авагчийн зөвшөөрөлгүй хаяг солихыг хориглоно.

34.8.Тээвэрлэгч нь энэ хууль болон төмөр замын тээврийн дүрэм, журам, зааварт зааснаас бусад үндэслэлээр үйлчилгээ үзүүлэхээс татгалзахыг хориглоно.

34.9.Тээвэрлэгч нь ачаа илгээгч, ачаа хүлээн авагч хүн, хуулийн этгээдийн өмчлөл, эзэмшлийн вагоныг зөвшөөрөлгүй тээвэрлэлтэд ашиглахыг хориглоно.

35 дугаар зүйл.Тээвэрлэлтийн явцад үүссэн хохирол барагдуулах

35.1.Төмөр замын тээвэрлэлтийн явцад үүссэн хохирол барагдуулах, түүнтэй холбоотой маргааныг Иргэний хууль⁸, төмөр замын тээврийн дүрэм, журам болон гэрээгээр зохицуулна.

36 дугаар зүйл.Тээврийн акт тогтоох

36.1.Тээвэрлэгч нь тээвэрлэлтийн явцад ачаа дутах, гэмтэх, муудах тохиолдолд ачаа илгээгч, ачаа хүлээн авагчтай хамтран бодит хохирлын хэмжээг тээврийн актаар тогтооно.

36.2.Энэ хуулийн 36.1-д зааснаас бусад тохиолдолд тээвэрлэгчийн тээврийн акт тогтоох ажиллагаанд хөндлөнгийн этгээдийг оролцуулж болно.

36.3.Тээвэрлэгчийн тээврийн актын загвар, түүнийг үйлдэх зааврыг энэ хуулийн 11.1.2, 11.1.3-т заасан дүрмээр тогтооно.

36.4.Тээвэрлэгч дараах нөхцөлд ачаа, тээш, ачаан тээшинд тээврийн акт тогтооно:

36.4.1.тээвэрлэлтийн бичиг баримтад заасан жин, байрны тоо, нэр зөрсөн;

36.4.2.ачаа, тээш, ачаан тээш гэмтсэн, муудсан, үрэгдсэн;

36.4.3.бичиг баримтгүй ачаа, тээш, ачаан тээш илэрсэн;

36.4.4.ачаа, тээш, ачаан тээшгүй тээвэрлэлтийн бичиг баримт илэрсэн;

36.4.5.хулгайлагдсан, дутсан ачаа, тээш, ачаан тээшийг тээвэрлэгчид буцаан өгсөн;

⁸ Иргэний хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2002 оны 7 дугаарт нийтлэгдсэн.



36.4.6.хөдлөх бүрэлдэхүүн, чингэлгээс ачаа олгох бичиг баримт үйлдсэнээс хойш 24 цагийн дотор тээвэрлэгч ачааг буулгалтын замд тавиагүй тохиолдолд ачаа хүлээн авагчийн шаардлагаар.

37 дугаар зүйл.Тусгай тээвэрлэлт

37.1.Тусгай тээвэрлэлтэд цэргийн, онцгой нөхцөл байдлын үеийн тээвэрлэлт хамаарна.

37.2.Гамшгаас хамгаалах тухай хуульд заасан онцгой нөхцөл байдал үүссэн үед Засгийн газар, Улсын онцгой комиссын шийдвэрээр төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагааг зохион байгуулна.

38 дугаар зүйл.Аюултай ачааны тээвэрлэлт

38.1.Төмөр замаар аюултай ачааг тээвэрлэлтэд бэлтгэх, ачих, тээвэрлэх, буулгах, шилжүүлэх, хадгалах үйл ажиллагааг энэ хуулийн 11.1.23-т заасан журмаар зохицуулна.

38.2.Аюултай ачааны ачилт, буулгалт хийх зориулалттай өртөөг сум, дүүргийн Засаг даргын саналыг үндэслэн төрийн захиргааны байгууллага тодорхойлно.

38.3.Аюултай ачаа ачиж, буулгах үйл ажиллагааг зориулалтын тоног төхөөрөмж бүхий зам, талбайд стандартын шаардлагын дагуу гүйцэтгэнэ.

38.4.Зорчигч галт тэргэнд аюултай ачаа биедээ авч явахыг хориглоно.

ДОЛДУГААР БҮЛЭГ ХӨДЛӨХ БҮРЭЛДЭХҮҮН

39 дүгээр зүйл.Хөдлөх бүрэлдэхүүн, түүний эд ангийг үйлдвэрлэх, угсрах, засварлахад тавих шаардлага

39.1.Хөдлөх бүрэлдэхүүн нь төмөр замын тээврийн дүрэм, журам, техникийн зохицуулалт, норм, стандартад нийцсэн байна.

39.2.Хөдлөх бүрэлдэхүүнийг улсын бүртгэлд бүртгүүлж, дугаар, гэрчилгээ авсан байна.

39.3.Хөдлөх бүрэлдэхүүн нь технологийн болон хөдөлгөөний хяналтын системд холбогдох боломжоор хангагдсан байна.

39.4.Хөдлөх бүрэлдэхүүн нь тогтоосон хугацаанд засвар, үйлчилгээнд хамрагдсан байна.

39.5.Хөдлөх бүрэлдэхүүн, түүний эд ангийг үйлдвэрлэх, угсрах, засварлах ажлыг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр гүйцэтгэнэ.

39.6.Энэ хуулийн 39.5-д заасан эрх бүхий этгээд нь хийсэн засвар, үйлчилгээндээ чанарын баталгаа гаргана.

40 дүгээр зүйл.Хөдлөх бүрэлдэхүүн өмчлөгч, эзэмшигчийн эрх, үүрэг

40.1.Хөдлөх бүрэлдэхүүн өмчлөгч, эзэмшигч нь хөдлөх бүрэлдэхүүнийг гэрээний үндсэн дээр тээвэрлэгчид ашиглуулах, тээвэрлэлтийн ажлын технологи, төмөр замын суурь бүтцийн техникийн байдал нь хөдлөх бүрэлдэхүүний техникийн байдалд сөргөөр нөлөөлөх бол үйлчилгээ үзүүлэхээс татгалзах эрхтэй.

40.2.Хөдлөх бүрэлдэхүүн өмчлөгч, эзэмшигч нь төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангах, хөдлөх бүрэлдэхүүнд засвар, техникийн үйлчилгээ хийх үүрэгтэй.

40.3.Хөдлөх бүрэлдэхүүн өмчлөгч, эзэмшигч нь хөдлөх бүрэлдэхүүнийг байрлуулах өөрийн эзэмшлийн болон түрээсээр ашиглах салбар замтай байна.

41 дүгээр зүйл.Хөдлөх бүрэлдэхүүний ашиглалт

41.1.Хөдлөх бүрэлдэхүүн ашиглалт, засвар үйлчилгээтэй холбогдсон харилцааг энэ хуулийн 11.1.11-д заасан журмаар зохицуулна.

41.2.Хөдлөх бүрэлдэхүүний хийц бүтээцийг төрийн захиргааны байгууллагын зөвшөөрөлгүй өөрчлөхийг хориглоно.

НАЙМДУГААР БҮЛЭГ ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

42 дугаар зүйл.Төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангах

42.1.Төмөр замын тээврийн аюулгүй байдал нь төмөр замын тээврийн тасралтгүй, хэвийн үйл ажиллагааг хангах, зорчигч аюулгүй зорчих нөхцөлийг бүрдүүлэх, ачаа, тээш, ачаан тээшийг бүрэн бүтэн тээвэрлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх цогц үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд чиглэсэн байна.

42.2.Төрийн захиргааны болон төмөр замын тээврийн байгууллага нь төмөр замын тээврийн талаарх хууль тогтоомж, төмөр замын тээврийн дүрэм, журам, техникийн баримт бичиг, норм, стандартын хэрэгжилт болон төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангах ажлыг зохион байгуулна.

42.3.Төмөр замын суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч нь байгалийн гамшиг, төмөр замын тээврийн аюулгүй байдал алдагдахаас урьдчилан сэргийлэх, суурь бүтцийг сэргээн босгох зориулалтын машин механизм, техник хэрэгсэл, материалын нөөцийн бэлэн байдлыг хангасан байна.

42.4.Төмөр замын тээврийн байгууллага, салбар зам эзэмшигч нь хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу түргэн шуурхай хэрэгжүүлнэ.

42.5.Төмөр замын тээврийн байгууллага нь төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангах дотоод хяналтыг хэрэгжүүлнэ.

42.6.Төмөр замын тээврийн байгууллага нь төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр дараах үйл ажиллагааг зохион байгуулна:

42.6.1.зорчигч аюулгүй зорчих нөхцөлийг бүрдүүлэх;
42.6.2.галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах;

42.6.3.ачаа, тээш, ачаан тээшийг аюулгүй, бүрэн бүтэн тээвэрлэх;

42.6.4.төмөр замын тээврийн байгууллагын ажилтны аюулгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлэх;

42.6.5.хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр ажиллах.

42.7.Төмөр замын суурь бүтцийг эрчим хүчээр тасалдалгүй хангах онцгой объект гэж үзнэ.

43 дугаар зүйл.Төмөр замын тээврийн аюулгүй байдлын шаардлага

43.1.Төмөр замын суурь бүтэц, салбар зам, хөдлөх бүрэлдэхүүн, техник хэрэгсэл нь энэ хууль болон төмөр замын тээврийн дүрэм, журам, техникийн баримт бичиг, стандарт, норм, нормативын баримт бичгийн шаардлагыг хангасан байна.

43.2.Энэ хуулийн 43.1-д заасан шаардлагыг хангаагүй суурь бүтэц, салбар зам, хөдлөх бүрэлдэхүүн, техник хэрэгслийг ашиглахыг хориглоно.

43.3.Төмөр замын зориулалтын гарам, гарцгүй газраар хүн, техник хэрэгсэл нэвтрэх, зурвас газарт мал бэлчээхийг хориглоно.

43.4.Төмөр замын гармын аюулгүй байдлыг төмөр замын суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч болон салбар зам эзэмшигч хариуцна.

43.5.Төмөр замын тээвэрт ашиглах тусгай зориулалтын багаж, хэрэгсэл нь бүртгэл, дугаар, хяналттай байх бөгөөд түүнийг ашиглах харилцааг энэ хуулийн 11.1.15-д заасан журмаар зохицуулна.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ТАРИФ, ДААТГАЛ

44 дүгээр зүйл.Төмөр замын тээврийн тариф

44.1.Төмөр замын суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч, тээвэрлэгч, салбар зам эзэмшигч нь энэ хуулийн 11.1.20-д заасан аргачлалын дагуу тариф тогтооно.

44.2.Төмөр замын тээврийн байгууллага нь Өрсөлдөөний тухай хуулийн⁹ 6.1-д зааснаас бусад тохиолдолд төрийн захиргааны байгууллагын зөвшөөрөлгүйгээр тээврийн тарифт өөрчлөлт оруулахыг хориглоно.

44.3.Тээврийн тарифын өөрчлөлтийг мөрдөж эхлэхээс 10-аас доошгүй хоногийн өмнө нийтэд мэдээлнэ.

44.4.Төмөр замын тээврийн байгууллага нь тээврийн тарифыг цахим хуудас, мэдээллийн самбар, мэдээллийн бусад хэрэгслээр олон нийтэд албан ёсоор мэдээлэхгүйгээр мөрдөхийг хориглоно.

44.5.Төрийн захиргааны байгууллагын дэргэд төмөр замын тээврийн тарифыг оновчтой тогтоох асуудлаар дүгнэлт, зөвлөмж гаргах үүрэг бүхий Төмөр замын тээврийн тарифын орон тооны бус зөвлөл /цаашид “Зөвлөл” гэх/ ажиллах бөгөөд Зөвлөлийн дүрмийг төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

44.6.Энэ хуулийн 44.5-д заасан Зөвлөлийн дарга, гишүүнийг төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн төрийн захиргааны байгууллагын дарга томилж, чөлөөлөх ба нарийн бичгийн дарга нь орон тооны байна.

44.7.Зөвлөл нь эдийн засаг, хөгжлийн, төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын болон Шударга

⁹ Өрсөлдөөний тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2010 оны 28 дугаарт нийтлэгдсэн.



өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын төлөөллөөс гадна ашгийн ба ашгийн бус хуулийн этгээдийн төлөөллийг оролцуулсан таван хүний бүрэлдэхүүнтэй байна.

45 дугаар зүйл. Төмөр замын тээврийн даатгал

45.1. Төмөр замын тээврийн байгууллага нь дараах ажилтныг гэнэтийн ослын даатгалд заавал хамруулна:

45.1.1. галт тэрэгний хөдөлгөөнтэй шууд холбоотой;

45.1.2. төмөр замын аюултай бүсэд ажилладаг;

45.1.3. галт тэрэг, хөдлөх бүрэлдэхүүн, суурь бүтцэд хяналт, шалгалт хийдэг;

45.1.4. төмөр замын суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүний эд ангийг үйлдвэрлэх, угсрах, засварлах, тоног төхөөрөмж, техник хэрэгслийг турших, оношлох ажилд оролцдог.

45.2. Энэ хуулийн 45.1-д заасан даатгалын зардлыг ажил олгогч хариуцна.

45.3. Төмөр замын суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүн, чингэлэг, төмөр замаар тээвэрлэх ачааг холбогдох хууль тогтоомжид заасан журмын дагуу даатгалд хамруулж болно.

АРАВДУГААР БҮЛЭГ ТӨМӨР ЗАМЫН АЖИЛТНЫ ХӨДӨЛМӨРИЙН ХАРИЛЦАА

46 дугаар зүйл. Төмөр замын тээврийн байгууллагын ажилтны хөдөлмөрийн харилцаа

46.1. Төмөр замын тээврийн салбарын ажилтныг ажил, чиг үүргээс нь хамааруулан галт тэрэгний хөдөлгөөнтэй шууд ба шууд бус холбоотой гэж ангилах бөгөөд ажилтны хөдөлмөр эрхлэлтийн харилцаа, нөхцөлийг энэ хууль, Хөдөлмөрийн тухай¹⁰ хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомж болон энэ хуулийн 11.1.13-т заасан журмаар зохицуулна.

46.2. Галт тэрэгний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажилтан ажилд анх орохдоо эмнэлгийн урьдчилсан үзлэгт, ажил гүйцэтгэх явцад хугацаат үзлэгт хамрагдах үүрэгтэй.

46.3. Төмөр замын тээврийн байгууллагын ажилтан албаны хувцас хэрэглэх бөгөөд энэ хуулийн 11.1.18-д заасан журмаар зохицуулна.

¹⁰ Хөдөлмөрийн тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2021 оны 31 дугаарт нийтлэгдсэн.

47 дугаар зүйл. Ажилтны нийгмийн баталгаа

47.1. Төмөр замын тээврийн байгууллагад 25 болон түүнээс дээш жил ажилласан эрэгтэй, 20 болон түүнээс дээш жил ажилласан эмэгтэй ажилтан төмөр замын тээврийн байгууллагаас өндөр насны тэтгэвэр тогтоолгосон бол 10-аас доошгүй сарын дундаж цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламж олгоно.

47.2. Энэ хуулийн 47.1-д заасан нийгмийн баталгаатай холбогдон гарах зардлыг ажил олгогч хариуцах бөгөөд буцалтгүй тусламж олгох асуудлыг тухайн төмөр замын тээврийн байгууллага хөдөлмөрийн дотоод журмаар зохицуулна.

47.3. Төмөр замын тээврийн байгууллагын ажилтанг мэргэшүүлэх, мэргэжлийн зэрэг дээшлүүлэхэд ажил олгогч дэмжлэг үзүүлж болно.

АРВАННЭГДҮГЭЭР БҮЛЭГ БУСАД

48 дугаар зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

48.1. Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хууль¹¹, Хөдөлмөрийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

48.2. Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль¹², эсхүл Зөрчлийн тухай¹³ хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

49 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

49.1. Энэ хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

¹¹ Төрийн албаны тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2018 оны 01 дугаарт нийтлэгдсэн.

¹² Эрүүгийн хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2016 оны 07 дугаарт нийтлэгдсэн.

¹³ Зөрчлийн тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2017 оны 24 дугаарт нийтлэгдсэн.



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 07 дугаар
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.2007 оны 07 дугаар сарын 05-ны өдөр баталсан Төмөр замын тээврийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Төмөр замын тээврийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Монгол Улсын
Их Хурлын дарга

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ᠤᠨ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠋᠎

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ᠤᠨ
ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠋᠎

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ᠤᠨ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠋᠎
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ᠤᠨ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠋᠎
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ᠤᠨ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠋᠎

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ᠤᠨ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠋᠎
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ᠤᠨ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠋᠎
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ᠤᠨ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠋᠎

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ᠤᠨ
ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠋᠎



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 07 дугаар
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Зөрчлийн тухай хуулийн 14.10 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“14.10 дугаар зүйл. Төмөр замын тээврийн тухай хууль зөрчих

1. Төмөр замын тээврийн аюулгүй байдал алдагдахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ аваагүй, осол, зөрчлийг шинжлэн шалгахад болон төмөр замын суурь бүтцийг сэргээн босгох үйл ажиллагаанд саад учруулсан бол хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2. Төмөр замын тээврийн дүрэм, журмыг зөрчсөн бол буруутай этгээдээс учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж, хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3. Хуульд заасныг зөрчиж:

3.1. Төмөр замын тусгай бүсэд зөвшөөрөлгүй нэвтэрсэн, үйл ажиллагаа явуулсан, галт тэрэгний хөдөлгөөнийг саатуулсан, зогсоосон, хөдлөх бүрэлдэхүүний дээвэр, гишгүүр дээр зорчсон, төмөр зам дээр эд зүйл байрлуулсан, мал, ердийн хөсгийг төмөр замын гарамгүй гарцаар гаргасан;

3.2. Төмөр замын тээврийн зориулалттай газарт мал бэлчээсэн, төмөр замын тээвэрт холбогдолгүй ажил, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлсэн, зориулалтын бус барилга, байгууламж барьсан, объект байрлуулсан, Төмөр замаар аюултай ачаа тээвэрлэх ачиж, буулгах, хадгалах журмыг зөрчсөн бол хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4. Шаардлага хангаагүй төмөр замын суурь бүтэц, салбар зам, хөдлөх бүрэлдэхүүн, техник хэрэгслийг төмөр замын тээвэрт ашигласан бол хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.



5.Төмөр замын суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч, тээвэрлэгч, салбар зам эзэмшигч нь бусдын үйл ажиллагаанд үндэслэлгүйгээр саад учруулсан бол хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

6.Тээвэрлэгч нь бусдын эзэмшлийн хөдлөх бүрэлдэхүүнийг эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр тээвэрт ашигласан, ачилтад авсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

7.Төмөр замын тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэх үйл ажиллагааг:

7.1.тусгай зөвшөөрөлгүй;

7.2.тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага хангаагүй;

7.3.тусгай зөвшөөрлийг бусдад шилжүүлж;

7.4.бусдын тусгай зөвшөөрлөөр эрхэлсэн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

8.Төмөр замын тээврийн тухай хуульд заасан үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Төмөр замын тээврийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 07 дугаар
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

УЛСЫН ТЭМДЭГГИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд доор дурдсан агуулгатай 29.1.13 дахь заалт нэмсүгэй:

“29.1.13.төмөр замын зураг төсөл боловсруулах болон техник, технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл олгоход зөвшөөрөл тус бүрд 5 000 000 төгрөг.”

2 дугаар зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 29.1.1-29.1.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“29.1.1.төмөр замын суурь бүтэц барих болон ашиглах тусгай зөвшөөрөл олгоход зөвшөөрөл тус бүрд 16 000 000 төгрөг;

29.1.2.төмөр замын суурь бүтэц болон хөдлөх бүрэлдэхүүн, тэдгээрийн эд анги үйлдвэрлэх, угсрах, засварлах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход зөвшөөрөл тус бүрд 5 000 000 төгрөг;

29.1.3.төмөр замын тээвэрлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 16 000 000 төгрөг;”

3 дугаар зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн “29.1.1, 29.1.2, 29.1.3,” гэснийг хассугай.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Төмөр замын тээврийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 07 дугаар
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийн 5.1 дэх заалтын “Засгийн газар” гэснийг “Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэж, 5.7 дахь заалтын “тээвэрлэлтийн” гэснийг “тээвэрлэгчийн” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Төмөр замын тээврийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Mongol Folk _ on Nall

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ᠤᠨ ᠬᠤᠠᠭᠤᠯᠠᠭᠤ ᠬᠤᠷᠭᠠᠨ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ᠤᠨ
ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ

ᠠᠨᠠᠭᠤᠯᠠᠭᠤ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ
ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ
ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ
ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ
ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ

ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ
ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ
ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ
ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ
ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ

ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ
ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 07 дугаар
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

БАРИЛГЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Барилгын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.5 дахь заалтын “төмөр зам,” гэснийг хассугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Төмөр замын тээврийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Mongol.Folio_02.html

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠠᠭᠤᠯᠠᠭ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ
ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠠᠭᠤᠯᠠᠭ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠠᠭᠤᠯᠠᠭ
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠠᠭᠤᠯᠠᠭ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠠᠭᠤᠯᠠᠭ
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠠᠭᠤᠯᠠᠭ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠠᠭᠤᠯᠠᠭ
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠠᠭᠤᠯᠠᠭ



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 07 дугаар
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/-ИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

1 дүгээр зүйл.Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Төмөр замын тээврийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн хэрэгжилтийг хангахад шаардлагатай дүрэм, журам, норм, аргачлалыг боловсруулж, батлах, хууль тогтоомжийг сурталчлах, бүтэц орон тоо батлуулах, удирдлага зохион байгуулалтын болон техник хэрэгсэл, санхүү, эдийн засгийн холбогдох арга хэмжээг 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор зохион байгуулна.

2 дугаар зүйл.Төмөр замын тээврийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөхөөс өмнө тухайн үед мөрдөж байсан хууль тогтоомжийн дагуу олгосон суурь бүтэц барих, ашиглах, төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхлэх болон суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүнийг үйлдвэрлэх, угсрах, засварлах тусгай зөвшөөрөл нь уг зөвшөөрөлд заасан хугацаанд хүчин төгөлдөр байна.

3 дугаар зүйл.Төмөр замын тээврийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөхөөс өмнө тухайн үед мөрдөгдөж байсан хууль тогтоомжийн дагуу олгосон төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зарим объект, үйл ажиллагаанд олгосон гэрчилгээ нь уг гэрчилгээнд заасан хугацаанд хүчин төгөлдөр байна.

4 дүгээр зүйл.Төмөр замын зураг төсөл боловсруулах, техник, технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээ, суурь бүтцийн болон хөдлөх бүрэлдэхүүний эд ангийг үйлдвэрлэх, угсрах, засварлах үйл ажиллагааг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр хэрэгжүүлэхээр зохицуулсан Төмөр замын тээврийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн болон хамт баталсан Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн зүйл, хэсэг, заалтыг Зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу холбогдох зөвшөөрлийг нэмэх, задлах, хуваах, салгах, түүний хамрах хүрээг өргөжүүлэх асуудлыг шийдвэрлэсний дараа дагаж мөрдөнө.

5 дугаар зүйл.Төмөр замын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны урсгал зардлыг 2024 оны улсын төсөвт тусгаж шийдвэрлэнэ.

6 дугаар зүйл.Энэ хуулийг Төмөр замын тээврийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛЫН ХУУЛЬ
/Хуульчилсан бичлэг/
2023 он 12 сар 20 - 21

1. Хуульчилсан бичлэг... МОНГОЛЫН ХУУЛЬ /Хуульчилсан бичлэг/ - 2023 он 12 сар 20 - 21
МОНГОЛЫН ХУУЛЬ /Хуульчилсан бичлэг/ - 2023 он 12 сар 20 - 21
МОНГОЛЫН ХУУЛЬ /Хуульчилсан бичлэг/ - 2023 он 12 сар 20 - 21
МОНГОЛЫН ХУУЛЬ /Хуульчилсан бичлэг/ - 2023 он 12 сар 20 - 21

2. Хуульчилсан бичлэг... МОНГОЛЫН ХУУЛЬ /Хуульчилсан бичлэг/ - 2023 он 12 сар 20 - 21
МОНГОЛЫН ХУУЛЬ /Хуульчилсан бичлэг/ - 2023 он 12 сар 20 - 21
МОНГОЛЫН ХУУЛЬ /Хуульчилсан бичлэг/ - 2023 он 12 сар 20 - 21
МОНГОЛЫН ХУУЛЬ /Хуульчилсан бичлэг/ - 2023 он 12 сар 20 - 21

3. Хуульчилсан бичлэг... МОНГОЛЫН ХУУЛЬ /Хуульчилсан бичлэг/ - 2023 он 12 сар 20 - 21
МОНГОЛЫН ХУУЛЬ /Хуульчилсан бичлэг/ - 2023 он 12 сар 20 - 21
МОНГОЛЫН ХУУЛЬ /Хуульчилсан бичлэг/ - 2023 он 12 сар 20 - 21
МОНГОЛЫН ХУУЛЬ /Хуульчилсан бичлэг/ - 2023 он 12 сар 20 - 21

4. Хуульчилсан бичлэг... МОНГОЛЫН ХУУЛЬ /Хуульчилсан бичлэг/ - 2023 он 12 сар 20 - 21
МОНГОЛЫН ХУУЛЬ /Хуульчилсан бичлэг/ - 2023 он 12 сар 20 - 21
МОНГОЛЫН ХУУЛЬ /Хуульчилсан бичлэг/ - 2023 он 12 сар 20 - 21
МОНГОЛЫН ХУУЛЬ /Хуульчилсан бичлэг/ - 2023 он 12 сар 20 - 21





МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 07 дугаар
сарын 07-ны өдөр

Дугаар 71

Улаанбаатар
хот

Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2020 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 07 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч”-ийн Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний “Засгийн газрын тохируулагч агентлаг” гэсэн хэсэгт “10.Иргэний нисэхийн ерөнхий газар” гэж нэмсүгэй.

2.“Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2020 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 07 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч”-ийн Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний “Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг” гэсэн хэсгийн “20.Иргэний нисэхийн ерөнхий газар” гэснийг хассугай.

3.“Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2020 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 07 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч”-ийн “Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг” гэсэн хэсгийн “21, 22, 23, 24, 25, 26, 27, 28, 29” гэсэн дугаарыг “20, 21, 22, 23, 24, 25, 26, 27, 28” гэж тус тус өөрчилсүгэй.

4.Иргэний нисэхийн ерөнхий газрын орон тооны дээд хязгаарыг хууль тогтоомжид нийцүүлэн батлахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай.

5.Энэ тогтоолыг Иргэний нисэхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

Модуль Folo_02 Vaki Hor&_02 Daaelaga

᠑᠙᠙᠘ - ᠒᠐᠒᠓ онд үргэлжлэн үргэлжлүүлж

᠒᠑ үргэлжлүүлж

үргэлжлүүлж

᠑᠙᠙᠘ - ᠒᠐᠒᠓ онд үргэлжлэн үргэлжлүүлж

᠑᠙᠙᠘ - ᠒᠐᠒᠓ онд үргэлжлэн үргэлжлүүлж

᠑᠙᠙᠘ - ᠒᠐᠒᠓ онд үргэлжлэн үргэлжлүүлж

᠑᠙᠙᠘ - ᠒᠐᠒᠓ онд үргэлжлэн үргэлжлүүлж

᠑᠙᠙᠘ - ᠒᠐᠒᠓ онд үргэлжлэн үргэлжлүүлж

᠑᠙᠙᠘ - ᠒᠐᠒᠓ онд үргэлжлэн үргэлжлүүлж

᠑᠙᠙᠘ - ᠒᠐᠒᠓ онд үргэлжлэн үргэлжлүүлж

᠑᠙᠙᠘ - ᠒᠐᠒᠓ онд үргэлжлэн үргэлжлүүлж

᠑᠙᠙᠘ - ᠒᠐᠒᠓ онд үргэлжлэн үргэлжлүүлж

᠑᠙᠙᠘ - ᠒᠐᠒᠓ онд үргэлжлэн үргэлжлүүлж

᠑᠙᠙᠘ - ᠒᠐᠒᠓ онд үргэлжлэн үргэлжлүүлж

᠑᠙᠙᠘ - ᠒᠐᠒᠓ онд үргэлжлэн үргэлжлүүлж



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 07 дугаар
сарын 07-ны өдөр

Дугаар 72

Улаанбаатар
хот

Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2020 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 07 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч”-ийн Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний “Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг” гэсэн хэсэгт “20.Төмөр замын газар” гэж нэмсүгэй.

2.“Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2020 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 07 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч”-ийн “Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг” гэсэн хэсгийн “20, 21, 22, 23, 24, 25, 26, 27, 28” гэсэн дугаарыг “21, 22, 23, 24, 25, 26, 27, 28, 29” гэж өөрчилсүгэй.

3.Төмөр замын газрын орон тооны дээд хязгаарыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн батлахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай.

4.Энэ тогтоолыг Төмөр замын тээврийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 02 дугаар
сарын 01-ний өдөр

Дугаар 42

Улаанбаатар
хот

Дүрэм, журам батлах тухай

Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 10.1.8, 11.3-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Кибер аюулгүй байдлын зөвлөлийн дүрэм”-ийг 1 дүгээр хавсралт, “Кибер аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны ажиллах журам”-ыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2.Кибер аюулгүй байдлын зөвлөл, түүний Ажлын албаны үйл ажиллагааны зардлыг 2023 оны батлагдсан төсөв, орон тоондоо багтаан хэрэгжүүлэх, цаашид шаардагдах зардлыг жил бүрийн улсын төсвийн төсөлд тусгуулж байхыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учралд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

**ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА
ХОЛБООНЫ САЙД**

Н.УЧРАЛ

Засгийн газрын 2023 оны 02 дугаар
сарын 01-ний өдрийн 42 дугаар
тогтоолын 01 дүгээр хавсралт

КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН ДҮРЭМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Кибер аюулгүй байдлын зөвлөл (цаашид “Зөвлөл” гэх) Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 11.4-т заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэхдээ энэ дүрмийг баримтална.

1.2. Зөвлөл нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын тухай, Зэвсэгт хүчний тухай, Төрийн болон албаны нууцын тухай, Харилцаа холбооны тухай, Тагнуулын байгууллагын тухай, Байгууллагын нууцын тухай, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай, Цахим гарын үсгийн тухай, Кибер аюулгүй байдлын тухай хууль болон тэдгээрт нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомж, энэ дүрмийг удирдлага болгоно.

Хоёр. Зөвлөлийн бүрэлдэхүүн, зохион байгуулалт

2.1. Зөвлөл нь холбогдох төрийн байгууллага, кибер халдлага, зөрчилтэй тэмцэх төв, энэ чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч төрийн өмчит хуулийн этгээдийн төлөөлөл бүхий орон тооны бус гишүүдээс бүрдэнэ.

2.3. Зөвлөл нь тогтоосон журмын дагуу үйлдсэн тамга, тэмдэг, хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

2.4. Зөвлөлийн Ажлын албаны даргыг цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилж, чөлөөлнө.

Гурав. Зөвлөлийн хуралдаан

3.1. Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байх бөгөөд улиралд 1-ээс доошгүй удаа хуралдана. Зөвлөлийн ээлжит бус хуралдааныг зөвлөлийн даргын санаачилгаар зарлан хуралдуулж болно.

3.2. Зөвлөлийн гишүүдийн гуравны хоёр нь оролцсоноор хуралдааныг хүчинтэйд тооцно. Гишүүн хуралдаанд биечлэн оролцох боломжгүй бол цахимаар оролцож болно.

3.3. Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудал, гаргах шийдвэрийн төсөл, холбогдох материалыг Ажлын алба боловсруулж, дэд дарга нарт танилцуулсны үндсэн дээр зөвлөлийн даргад танилцуулна.

3.4. Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцсэн асуудлыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ.

3.5. Хүндэтгэн үзэх шалтгаанаар хуралдаанд оролцоогүй гишүүний бичгээр ирүүлсэн саналыг хүчинтэйд тооцно. Гишүүдийн санал тэнцсэн тохиолдолд асуудлыг хуралдаан даргалагчийн саналаар шийдвэрлэнэ.

3.6.Зөвлөлийн хуралдаанаас тогтоол, тэмдэглэл гарах бөгөөд тогтоолд зөвлөлийн дарга, дэд дарга нар гарын үсэг зурна.

3.7.Кибер аюулгүй байдлыг хангах чиглэлээр гаргасан зөвлөлийн шийдвэрийг холбогдох байгууллага, албан тушаалтан биелүүлж, хэрэгжилтийн тайлан, мэдээллийг тогтоосон хугацаанд зөвлөлийн Ажлын албанд ирүүлнэ.

3.8.Кибер аюулгүй байдлыг хангахтай холбоотой асуудлыг зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх байгууллага, зөвлөлийн гишүүн холбогдох материалаа зөвлөлийн Ажлын албанд урьдчилан хүргүүлнэ.

3.9.Хуралдаанаар хэлэлцэх асуудлын жагсаалт, холбогдох материалыг хуралдаан болохоос 3-аас доошгүй хоногийн өмнө зөвлөлийн дарга, дэд дарга, гишүүдэд цахим, эсхүл цаасан хэлбэрээр хүргүүлнэ.

3.10.Зөвлөлийн Ажлын албаны нарийн бичгийн дарга хуралдааны тэмдэглэл хөтөлж, хуралдаан даргалагч гарын үсэг зурж баталгаажуулна.

3.11.Шаардлагатай тохиолдолд зөвлөлийн үйл ажиллагаанд холбогдох төрийн байгууллагын төлөөлөл, кибер аюулгүй байдлын мэргэжилтэн, эрдэмтэн, судлаач, хувийн хэвшлийн төлөөллийг татан оролцуулна.

Дөрөв.Зөвлөлийн дарга, дэд дарга, гишүүний бүрэн эрх

4.1.Зөвлөлийн дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

4.1.1.кибер аюулгүй байдлыг хангах хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих үйл ажиллагааг зохион байгуулж, зөвлөлийн дэд дарга нар, гишүүдэд үүрэг, даалгавар өгөх;

4.1.2.зөвлөлийн ээлжит болон ээлжит бус хуралдаанаар хэлэлцэх асуудлыг тогтоож, хуралдааныг товлох, даргалах;

4.1.3.үндэсний хэмжээний кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах, холбогдох байгууллагын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;

4.1.4.зөвлөлийг дотоод, гадаад харилцаанд төлөөлөх.

4.2.Зөвлөлийн дэд дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

4.2.1.зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг санаачлах;

4.2.2.кибер аюулгүй байдлыг хангах чиглэлээр гаргасан зөвлөлийн шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах;

4.2.3.кибер аюулгүй байдлыг хангахтай холбоотой цаг үеийн нөхцөл байдлын талаар мэдээлэл хийх;

4.2.4.кибер аюулгүй байдлыг хангахтай холбоотой гадаад болон олон улсын байгууллагатай мэдээ, мэдээлэл солилцох, хамтран ажиллах талаар санал гаргах, зөвлөлийн хуралдаанд танилцуулах;

4.2.5.кибер аюулгүй байдлыг хангах чиглэлээр шинэ техник, технологи, инновацыг нэвтрүүлэх, холбогдох судалгаа, шинжилгээний ажлыг зохион байгуулж, үр дүнг танилцуулах;

4.2.6.зөвлөлийн даргын эрх олгосноор энэ журмын 4.1-д заасан эрхийг тухай бүр хэрэгжүүлэх;

4.2.7.кибер халдлага, зөрчилтэй тэмцэх холбогдох төвд бүртгэгдсэн халдлага, зөрчлийн талаарх мэдээлэл, мэдээллийн сан, системийг нөхөн сэргээх асуудлыг танилцуулах;

4.2.8.гадаад улсын зээл, тусламж, хөрөнгө оруулалтаар хэрэгжих мэдээллийн технологийн төсөл, хөтөлбөрт хийсэн кибер аюулгүй байдлын шалгалтын дүнгийн талаар танилцуулах.

4.3.Зөвлөлийн гишүүн дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

4.3.1.зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг санаачлах;

4.3.2.зөвлөлийн шийдвэр, үүрэг, даалгаврын хэрэгжилтийг хариуцсан салбар, чиглэлийн дагуу зохион байгуулах, үр дүнг тайлагнах;

4.3.3.зөвлөлийн даргын өгсөн үүргийн биелэлт, үр дүнг тайлагнах, хариуцсан салбар, чиглэлийн дагуу холбогдох тайлан, мэдээллээр хангах;

4.3.4.зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөлд санал өгөх, төлөвлөгөө, тайлантай танилцах, зөвлөлөөс хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар мэдээлэл авах;

4.3.5.хариуцсан салбар, чиглэлийн хүрээнд кибер аюулгүй байдлыг хангах, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх арга хэмжээг авч, хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр гарган зөвлөлийн Ажлын албанд хүргүүлэх;

4.3.6.хариуцсан салбарын мэдээллийн системд чиглэсэн кибер халдлага, зөрчил, түүнийг илрүүлэх, таслан зогсоох, хариу арга хэмжээний талаар танилцуулах;

4.3.7.хариуцсан салбар чиглэлийн хүрээнд кибер аюулгүй байдлын талаар танилцуулах;

4.3.8.кибер халдлага, зөрчилтэй холбоотой гэмт хэргийн талаарх мэдээ, мэдээллийг танилцуулах.

---o0o---



Засгийн газрын 2023 оны 02 дугаар
сарын 01-ний өдрийн 42 дугаар
тогтоолын 02 дугаар хавсралт

КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБАНЫ АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Кибер аюулгүй байдлын зөвлөлийн өдөр тутмын үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн болон зохион байгуулалтын дэмжлэг үзүүлэх, хуралдааны бэлтгэлийг хангах, зөвлөлөөс гарах шийдвэрийн төслийг боловсруулах, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, түүнд хяналт тавих ажлыг кибер аюулгүй байдлын зөвлөлийн ажлын алба (цаашид “Ажлын алба” гэх) хариуцан гүйцэтгэнэ.

1.2.Зөвлөл, түүний ажлын албаны үйл ажиллагаанд шаардагдах зардлыг цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний төсвийн багцад жил бүр тусгаж, санхүүжүүлнэ.

Хоёр.Ажлын албаны бүтэц, зохион байгуулалт

2.1.Ажлын алба нь цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний дэргэд ажиллана.

2.2.Ажлын албаны ажилтныг цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлагдсан орон тоо, цалингийн санд багтаан томилж, чөлөөлөх бөгөөд Ажлын албаны орлогч даргыг Тагнуулын ерөнхий газар санал болгоно.

2.3.Үндэсний хэмжээний кибер халдлага, зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, хариу арга хэмжээ авах үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах хүний нөөцийг Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх холбогдох төвүүдээс тухай бүр бүрдүүлэн ажиллаж болно.

Гурав.Ажлын албаны чиг үүрэг, удирдлага

3.1.Ажлын алба дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

3.1.1.кибер аюулгүй байдлын зөвлөлийн хуралдааны бэлтгэл ажлыг хангах, зөвлөлөөс гарсан шийдвэрийг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, хэрэгжилтийн тайланг гаргуулах, тэдгээрийг зөвлөлийн хуралдаанд танилцуулах;



3.1.2.кибер аюулгүй байдлын зөвлөлийн дарга, дэд дарга, гишүүнийг шаардлагатай мэдээллээр тухай бүр хангах;

3.1.3.үндэсний хэмжээний кибер халдлага, зөрчлийн талаарх тайлан, мэдээг нэгтгэн гаргаж, зөвлөлд танилцуулах;

3.1.4.зөвлөлөөс гарсан шийдвэр, зохион байгуулж байгаа үйл ажиллагаа, түүний явц, үр дүнгийн талаар олон нийтэд мэдээлж, сурталчлах;

3.1.5.кибер аюулгүй байдлыг хангахад шаардлагатай тайлан, мэдээлэл, судалгаа шинжилгээний баримт бичгийг холбогдох байгууллага, албан тушаалтнаас гаргуулан авах;

3.1.6.кибер аюулгүй байдлыг хангах хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;

3.1.7.Ажлын албаны хүний нөөцийг чадавхжуулах, мэргэшүүлэх;

3.1.8.зөвлөлийн архив, бичиг хэргийг хөтлөн явуулах;

3.1.9.зөвлөлийн дарга, дэд даргаас хариуцуулсан бусад ажил.

3.2.Ажлын албаны дарга нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

3.2.1.Ажлын албаны өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;

3.2.2.зөвлөл, Ажлын албаны үйл ажиллагаанд шаардагдах зардлын тооцоог гаргаж, зөвлөлийн хуралдаанд танилцуулах;

3.2.3.улсын төсвийн санхүүжилтийг сар, улирал, жилээр батлагдсан хуваарь, зориулалтын дагуу зарцуулах, тайлагнах;

3.2.4.зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг боловсруулах, зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулах;

3.2.5.тухайн жилд Ажлын албанаас хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайланг зөвлөлийн хуралдаанд танилцуулах;



3.2.6.ажил үүргээ гүйцэтгэх явцад олж авсан төрийн болон албаны, байгууллага, хувь хүний нууцыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хадгалж хамгаалах, Ажлын албаны ажилтантай нууцлалын гэрээ байгуулах.

3.3.Ажлын алба нь зөвлөлийн шийдвэр, хуралдааны тэмдэглэл, бусад баримт бичгийг зохих журмын дагуу хадгална.

----oOo----

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 5.75

Индекс: 200003